

**МОНГОЛ УЛС, ОРОСЫН ХОЛБООНЫ УЛСЫН
ХООРОНД ЭРХ ЗҮЙН ТУСЛАЛЦАА ҮЗҮҮЛЭХ,
ИРГЭНИЙ БА ЭРҮҮГИЙН ХЭРГИЙН ТАЛААРХ
ЭРХ ЗҮЙН ХАРИЛЦААНЫ ТУХАЙ ГЭРЭЭ**

(1999.04.20)

Монгол Улс, Оросын Холбооны Улс /цаашид "Хэлэлцэн тохирогч Талууд" гэх/ хоёр орны хоорондын найрсаг харилцааг цаашид хөгжүүлэх хүсэл эрмэлзлийг удирдлага болгон, эрх зүйн туслалцааны болон эрх зүйн харилцааны хүрээнд харилцан хамтын ажиллагааг гүнзгийрүүлэх хийгээд төгөлдөржүүлэхийг эрмэлзэн, доорх зүйлийг хэлэлцэн тохиров.Үүнд:

**Нэгдүгээр хэсэг
НИЙТЛЭГ ҮНДЭСЛЭЛ**

**1 дүгээр зүйл
Эрх зүйн хамгаалалт**

1. Хэлэлцэн тохирогч нэг Талын иргэн Хэлэлцэн тохирогч нөгөө талын нутаг дэвсгэр дээр хувийн болон эд хөрөнгийн талаар Хэлэлцэн тохирогч энэ Талын иргэний нэгэн адил эрх зүйн хамгаалалт эдэлнэ.
2. Хэлэлцэн тохирогч нэг Талын иргэн Хэлэлцэн тохирогч нөгөө Талын иргэний болон эрүүгийн хэргийг авч хэлэлцэх эрх бүхий байгууллагад чөлөөтэй, саадгүй хандах эрхтэй бөгөөд тэдгээрт хүсэлт, нэхэмжлэл гаргах, түүнчлэн байцаан шийтгэх бусад ажиллагаанд Хэлэлцэн тохирогч энэ Талын иргэний нэгэн адил нөхцөлөөр оролцох эрхтэй.
3. Хэлэлцэн тохирогч хоёр Талын иргэнийг хамаарсан энэхүү Гэрээний заалтууд Хэлэлцэн тохирогч нэг Талын хууль тогтоомжийн дагуу байгуулагдсан хуулийн этгээдэд нэгэн адил хамаарна.
4. Энэхүү Гэрээнд "иргэний хэрэг" гэдэгт хөдөлмөрийн хэрэг хамаарна.

**2 дугаар зүйл
Эрх зүйн туслалцаа үзүүлэх**

Хэлэлцэн тохирогч хоёр Талын хуулийн байгууллага буюу иргэний болон эрүүгийн хэргийн талаар эрх бүхий бусад байгууллага нь энэ хэргийн талаарх эрх зүйн туслалцааг харилцан үзүүлнэ. Энэхүү Гэрээний зорилгыг биелүүлэх хуулийн байгууллага гэдэгт,

Монгол Улсын хувьд: Монгол Улсын Хууль зүйн яамны байгууллагууд, прокурор, шүүх, Монгол Улсын Цагдаагийн Ерөнхий газар, нотариатын байгууллага, түүнчлэн өөрийн эрх мэдлийн асуудлаар бусад байгууллага;

ОХУ-ын хувьд: ОХУ-ын Хууль зүйн яамны байгууллагууд, ОХУ-ын Дотоод явдлын яам, прокурор, шүүх, нотариатын байгууллага түүнчлэн өөрийн эрх мэдлийн асуудлаар бусад байгууллага тус тус хамаарна.

**3 дугаар зүйл
Харилцах журам**

1. Энэхүү Гэрээнд хамаарах хэргийн талаар хуулийн байгууллагууд өөр хоорондоо харьцахдаа төв байгууллагаараа дамжуулан харилцана.
2. Энэхүү Гэрээний зорилгыг биелүүлэх төв байгууллага гэдэгт:
Монгол Улсын хувьд: - Монгол Улсын Хууль зүйн яам,
Монгол Улсын Ерөнхий прокурорын газар,
Монгол Улсын Цагдаагийн ерөнхий газар;

Оросын Холбооны Улсын хувьд: Оросын Холбооны Улсын Хууль зүйн яам,
Оросын Холбооны Улсын Дотоод явдлын яам,
Оросын Холбооны Улсын Ерөнхий прокурорын газар

тус тус хамаарна.

2. Хэлэлцэн тохирогч хоёр Талын иргэний болон эрүүгийн хэргийн талаар эрх бүхий байгууллагууд эрх зүйн туслалцаа үзүүлэх тухайд Хэлэлцэн тохирогч төв байгууллагаар дамжуулан хандана.
3. Хэлэлцэн тохирогч хоёр Талын хил орчмын хууль сахиулах байгууллагууд зарим асуудлаар өөр хоорондоо шууд харилцаж болохыг төв байгууллагууд харилцан зөвшилцөж шийдвэрлэнэ.

4 дүгээр зүйл

Харилцах хэл

5. Эрх зүйн туслалцаа үзүүлэх тухай хүсэлтийг хүсэлт өгсөн Хэлэлцэн тохирогч Талын хэл дээр үйлдэнэ.
6. Хэрэв энэхүү Гэрээний заалтын дагуу илгээж буй захидал болон баримт бичигт Хэлэлцэн тохирогч нөгөө Талын хэл дээрх орчуулгыг хавсаргах шаардлагатай бол уг орчуулгыг зохих ёсоор баталгаажуулсан байх ёстой.

5 дугаар зүйл

Эрх зүйн туслалцааны хүрээ

Хэлэлцэн тохирогч хоёр Тал нь хүсэлт хүлээн авсан Хэлэлцэн тохирогч Талын хууль тогтоомжид заасан байцаан шийтгэх тодорхой ажиллагаа явуулах замаар эрх зүйн туслалцааг харилцан үзүүлнэ. Тухайлбал, бичиг баримт үйлдэх, илгээх, гардуулж өгөх, нэгжлэг хийх, эд мөрийн нотлох баримт болон хэргийн материалыг шилжүүлэх, хүлээн авах, шинжилгээ хийх, зохигчид, гэрч, шинжээч, сэжигтэн, яллагдагч болон бусад этгээдийг байцаах, эрүүгийн байцаан шийтгэх ажиллагаа явуулах, эрүүгийн байцаан шийтгэх ажиллагаа явуулахаар буюу таслан шийдвэрлэх тогтоолыг биелүүлэхээр гэмт этгээдийг шилжүүлэн өгөх, ялтан этгээдийг ял эдлүүлэхээр шилжүүлэх, гэмт хэргийн үр дүнд авсан хөрөнгийг буцаах талаар арга хэмжээ авах, иргэний нэхэмжлэлийг хангах зорилгоор эд хөрөнгийг хураах, шүүхийн шийдвэрийг харилцан биелүүлэх, түүнчлэн **эрх зүйн туслалцаа харилцан үзүүлэх тухай бусад үйлдэл зэрэг** болно.

6 дугаар зүйл

Эрх зүйн туслалцаа үзүүлэх тухай даалгаврын агуулга, хэлбэр

1. Эрх зүйн туслалцаа үзүүлэх тухай даалгаварт дараахь зүйлийг тусгасан байна:
 - 1/даалгавар өгсөн байгууллагын нэр;
 - 2/даалгавар хүлээн авсан байгууллагын нэр;
 - 3/эрх зүйн туслалцаа үзүүлэх хэргийн нэр;
 - 4/зохигчид, сэжигтэн, яллагдагч буюу ялтан этгээдийн овог, нэр, тэдний байнга буюу түр оршин суугаа газар, иргэний харьяалал, эрхэлдэг ажил, түүнчлэн эрүүгийн хэргийн хувьд боломжтой бол төрсөн газар, он, сар, өдөр, тэдний эцэг, эхийн нэр, харин хуулийн этгээдийн хувьд түүний нэр болон оршин байгаа газар;
 - 5/4 дэх заалтад дурдсан этгээдүүдийг төлөөлөх хүмүүсийн овог, нэр, хаяг;
 - 6/даалгаврын гол утга болон түүнийг биелүүлэхэд зайлшгүй шаардлагатай мэдээ, хэрэв тодорхой бол гэрчийн овог, нэр, хаяг, төрсөн газар, он, сар, өдөр;
 - 7/эрүүгийн хэргийн талаар, түүнчлэн үйлдэгдсэн гэмт хэргийн талаарх нэмэлт тодорхойлолт, түүний хуулийн зүйлчлэл.
2. Эрх зүйн туслалцаа үзүүлэх тухай даалгаварт гарын үсэг зурж, даалгавар өгсөн байгууллагын албан ёсны тэмдэг дарсан байна.
3. Хэлэлцэн тохирогч хоёр Тал нь эрх зүйн туслалцаа үзүүлэх тухай даалгаварт хоёр хэл дээр хэвлэсэн хэвлэмэл хуудас хэрэглэж болно.

7 дугаар зүйл

Эрх зүйн туслалцаа үзүүлэх тухай даалгаврыг биелүүлэх

1. Эрх зүйн туслалцаа үзүүлэх тухай даалгавар хүлээн авсан байгууллага нь түүнийг биелүүлэхдээ өөрийн улсын хууль тогтоомжийг хэрэглэнэ. Хэрэв даалгавар хүлээн авсан Хэлэлцэн тохирогч Талын хууль тогтоомжид харшлахгүй бол даалгавар өгсөн байгууллагын хүсэлтээр даалгавар өгсөн Хэлэлцэн тохирогч Талын байцаан шийтгэх ажиллагааны хэм хэмжээг хэрэглэж болно.
2. Хэрэв даалгавар хүлээн авсан байгууллага уг даалгаврыг биелүүлэх эрх бүхий биш байвал түүнийг эрх бүхий байгууллагад шилжүүлэн өгч, энэ тухайгаа даалгавар өгсөн байгууллагад мэдэгдэнэ.
3. Даалгавар хүлээн авсан байгууллага нь түүнийг биелүүлсэн газар, хугацааг даалгавар өгсөн байгууллагын хүсэлтээр өөрт нь болон зохигчдод цаг тухайд нь мэдэгдэнэ.
4. Даалгаварт холбогдох этгээдийн хаяг тодорхой бус бол даалгавар хүлээн авсан байгууллага түүний хаягийг зөв тогтоох талаар зохих арга хэмжээ авна.

5. Даалгавар хүлээн авсан байгууллага нь даалгаврыг биелүүлсэн тухай бичиг баримтыг даалгавар өгсөн байгууллагад илгээнэ. Хэрэв даалгаврыг биелүүлэх боломжгүй бол даалгавар хүлээн авсан байгууллага нь даалгавар өгсөн байгууллагад биелүүлээгүй шалтгааныг мэдэгдэж, уг даалгаврыг буцаана.

8 дугаар зүйл **Гэрч буюу шинжээчийг дуудах**

1. Хэрэв Хэлэлцэн тохирогч аль нэг Талын нутаг дэвсгэр дээр урьдчилсан мөрдөн байцаалт явуулах буюу шүүхээр хэргийг хянан шийдвэрлэхэд Хэлэлцэн тохирогч нөгөө Талын нутаг дэвсгэрт байгаа гэрч буюу шинжээчийг дуудах шаардлага гарвал зарлан дуудах хуудас гардуулах тухай даалгаврын хамт Хэлэлцэн тохирогч энэ Талын холбогдох хуулийн байгууллагад хандаж болно.
2. Дуудагдаж буй этгээдийг ирээгүй тохиолдолд арга хэмжээ авах талаар зарлан дуудах хуудаст тусгасан байж болохгүй.
3. Хэлэлцэн тохирогч нөгөө Талын холбогдох байгууллагын дуудлагаар сайн дураар хүрэлцэн ирсэн гэрч буюу шинжээчийг аль улсын харьяат болохыг үл харгалзан тэр Талын нутаг дэвсгэрт гэмт хэрэгт буюу захиргааны зөрчилд холбогдуулан хариуцлагад татах, цагдан хорих буюу түүний улсын хилийг нэвтрэн орохын өмнө үйлдсэн ямар нэг үйлдэлд ял шийтгэж болохгүй. Уг этгээдүүдийг тэдний гаргасан мэдүүлэг буюу шинжээчийн дүгнэлт, эсхүл шалгаж буй үйлдэлтэй нь холбогдуулан гэмт хэрэг болон захиргааны зөрчлийн учир хариуцлагад татаж, цагдан хорьж, ял шийтгэж болохгүй.
4. Гэрч буюу шинжээч нь даалгавар өгсөн байгууллагаас цаашид байх шаардлагагүй гэж мэдэгдсэнээс хойш даалгавар өгсөн Хэлэлцэн тохирогч Талын нутаг дэвсгэрээс арван таван хоногийн дотор гарч яваагүй бол энэ зүйлийн 3 дахь хэсэгт заасан баталгааг алдана. Энэхүү хугацаанд гэрч буюу шинжээч нь даалгавар өгсөн Хэлэлцэн тохирогч Талын нутаг дэвсгэрээс өөрөөс нь үл шалтгаалах нөхцөл байдлын улмаас гарч явж чадаагүй хугацааг оруулан тооцохгүй.
5. Хэлэлцэн тохирогч нөгөө Талын нутаг дэвсгэрт дуудагдаж ирсэн гэрч буюу шинжээч нь хил нэвтрэх болон хилийн чанадад байх зардал, мөн ажлаасаа хөндийрсний улмаас ажиллаагүй өдрийн цалингаа нөхөн төлүүлэх, түүнчлэн шинжээчээр ажилласныхаа шагналыг авах эрхтэй. Дуудагдаж буй иргэн ямар зардал авах эрхтэйг зарлан дуудах хуудаст заасан байх ёстой. Дуудлага өгсөн Хэлэлцэн тохирогч Тал уг иргэний хүсэлтээр зардлын урьдчилгаа олгоно.

9 дүгээр зүйл **Баримт бичгийг гардуулах**

Даалгавар хүлээн авсан байгууллага нь гардуулан өгөх баримт бичгийг даалгавар хүлээн авсан Хэлэлцэн тохирогч Талын хэл дээр үйлдсэн буюу, эсхүл Хэлэлцэн тохирогч энэ Талын хэл дээрх баталгаат орчуулгыг хавсаргасан байвал өөрийн улсад дагаж мөрдөж байгаа журмын дагуу гардуулна. Хэрэв баримт бичиг нь даалгавар хүлээн авсан Хэлэлцэн тохирогч Талын хэл дээр үйлдээгүй буюу эсхүл орчуулагдаагүй байвал түүнийг хүлээн авагч нь сайн дураар хүлээн авахыг зөвшөөрвөл түүнд уг баримт бичгийг гардуулна.

10 дугаар зүйл **Баримт бичгийг гардуулсны баталгаа**

Баримт бичгийг гардуулсныг даалгавар хүлээн авсан байгууллагын албан ёсны тамга, баримт бичгийг гардуулж буй байгууллагын ажилтны гарын үсгээр баталгаажуулах бөгөөд гардуулсан он, сар, өдөр бүхий баримт бичиг, эсхүл гардуулан өгөх арга зам, газар, хугацааг заасан тухайн байгууллагын баримт бичигт хүлээн авсан хүн гарын үсэг зурсан байна.

11 дүгээр зүйл **Эрх зүйн туслалцаа үзүүлэх зардал**

1. Хэлэлцэн тохирогч Тал бүр өөрийн нутаг дэвсгэртээ гарсан эрх зүйн туслалцаа үзүүлэхтэй холбогдсон зардлыг хариуцна.
2. Даалгавар хүлээн авсан байгууллага гарсан зардлын хэмжээг даалгавар өгсөн байгууллагад мэдэгдэнэ. Хэрэв даалгавар өгсөн байгууллага уг зардлыг төлөх үүрэг бүхий этгээдээс гаргуулж авсан бол тэр нь зардлыг гаргуулахаар хүсэлт гаргасан Хэлэлцэн тохирогч Талын орлого болно.

12 дугаар зүйл **Мэдээлэл өгөх**

Хэлэлцэн тохирогч хоёр Талын төв байгууллагууд өөрийн оронд дагаж мөрдөж байгаа, эсхүл дагаж мөрдөж байсан хууль тогтоомжийн тухай болон түүнийг хуулийн байгууллагууд хэрэглэж буй асуудлаарх мэдээллийг хүсэлтийн дагуу харилцан бие биендээ өгч байна.

13 дугаар зүйл

Эд зүйл болон мөнгө шилжүүлэх

Хэрэв энэхүү Гэрээг биелүүлэхэд Хэлэлцэн тохирогч нэг Талын нутаг дэвсгэрээс Хэлэлцэн тохирогч нөгөө Талын нутаг дэвсгэрт, мөн Хэлэлцэн тохирогч нөгөө Талын дипломат төлөөлөгчийн буюу консулын газарт эд зүйл болон мөнгө шилжүүлбэл Хэлэлцэн тохирогч Талын шилжүүлж буй байгууллага өөрийн хууль тогтоомжийн дагуу гүйцэтгэнэ.

14 дүгээр зүйл

Хаяг болон бусад мэдээг тогтоох

1. Хэлэлцэн тохирогч хоёр Талын хуулийн байгууллагууд иргэний болон эрүүгийн хэргийн талаар эрх зүйн туслалцаа үзүүлэх хүрээнд хүсэлтийн дагуу өөрийн нутаг дэвсгэр дээр байгаа этгээдийн хаягийг тогтооход дэмжлэг үзүүлнэ.
2. Хэрэв Хэлэлцэн тохирогч нэг Талын шүүхэд Хэлэлцэн тохирогч нөгөө Талын нутаг дэвсгэрт байгаа этгээдээс тэтгэмж төлүүлэх тухай нэхэмжлэл гаргавал Хэлэлцэн тохирогч энэ Талын хуулийн байгууллага хүсэлтийн нь дагуу хариуцагчийн ажлын газар, орлогын хэмжээг тогтооход боломжийн хэрээр туслалцаа үзүүлнэ.

15 дугаар зүйл

Баримт бичгийг хүлээн зөвшөөрөх

1. Хэлэлцэн тохирогч нэг Талын эрх бүхий байгууллагын үйлдсэн албан ёсны тамга буюу эрх бүхий этгээдийн гарын үсэгтэй баримт бичгийг Хэлэлцэн тохирогч нөгөө Талын нутаг дэвсгэр дээр ямар нэгэн нотолгоогүйгээр хүлээн зөвшөөрнө.
Уг заалт нь холбогдох байгууллагаар баталгаажуулсан орчуулга, баримт бичгийн хуулбарт нэгэн адил хамаарна.
2. Хэлэлцэн тохирогч нэг Талын нутаг дэвсгэр дээр албан ёсны гэж хүлээн зөвшөөрөгдсөн баримт бичиг нь Хэлэлцэн тохирогч нөгөө Талын нутаг дэвсгэрт нэгэн адил хүлээн зөвшөөрөгдөнө.

16 дугаар зүйл

Иргэний гэр бүлийн байдлын бүртгэлийн тухай болон бусад баримт бичгийг илгээх

1. Хэлэлцэн тохирогч хоёр тал Хэлэлцэн тохирогч нөгөө Талын иргэний боловсрол, ажилласан хугацааны тухай болон хувийн эрх, ашиг сонирхолд нь хамаарах бусад баримт бичгийг харилцан хүссэний дагуу дипломат шугамаар орчуулгагүй болон үнэ төлбөргүй илгээх үүрэг харилцан хүлээнэ.
2. Хэлэлцэн тохирогч нэг Талын иргэний гэр бүлийн байдлыг бүртгэх байгууллага нь Хэлэлцэн тохирогч нөгөө Талын байгууллагын хүсэлтээр иргэний гэр бүлийн байдлын бүртгэлийн тухай баримт бичгийг орчуулгагүй болон үнэ төлбөргүй илгээнэ.

17 дугаар зүйл

Эрх зүйн туслалцаа үзүүлэхээс татгалзах

Хэрэв эрх зүйн туслалцаа үзүүлэх нь хүсэлт хүлээн авсан Хэлэлцэн тохирогч Талын тусгаар тогтнол, аюулгүй байдал, нийгмийн дэг журам болон бусад ашиг сонирхолд хохирол учруулахаар, түүнчлэн хууль тогтоомжийн үндсэн зарчим, олон улсын гэрээгээр хүлээсэн үүрэгт нь харшлахаар бол эрх зүйн туслалцааг үзүүлэхээс татгалзаж болно.

Хоёрдугаар хэсэг ИРГЭНИЙ ХЭРЭГ

18 дугаар зүйл Нийтлэг үндэслэл

Хэлэлцэн тохирогч хоёр Талын хуулийн байгууллага энэхүү Гэрээний заалтын дагуу ямар нэгэн асуудлаар эрх бүхий байхад хэрэг үүсгэх өргөдөл нь аль нэг Талын хуулийн байгууллагад өгөгдсөн бол нөгөө Талын холбогдох хуулийн байгууллага эрх бүхий байхаа болино.

НЭГДҮГЭЭР БҮЛЭГ
ХУВЬ ХҮНИЙ ЭРХ ЗҮЙН БАЙДАЛТАЙ ХОЛБОГДСОН АСУУДАЛ

19 дүгээр зүйл

Иргэний эрх зүйн эрхийн чадвар болон чадамж

1. Иргэний эрх зүйн эрхийн чадамжийг уг хүн харьяат нь байгаа Хэлэлцэн тохирогч Талын хууль тогтоомжийн дагуу тодорхойлно.
2. Хуулийн этгээдийн иргэний эрх зүйн эрхийн чадвар болон чадамжийг уг хуулин этгээдийг байгуулсан Хэлэлцэн тохирогч Талын хууль тогтоомжоор тодорхойлно.

20 дугаар зүйл

**Иргэний хязгаарлагдмал эрх зүйн
эрхийн чадамжтай буюу чадамжгүйд тооцох**

1. Иргэнийг иргэний хязгаарлагдмал эрх зүйн эрхийн чадамжтай буюу чадамжгүйд тооцоход хэрэв энэхүү Гэрээнд өөрөөр заагаагүй бол иргэний хязгаарлагдмал эрх зүйн эрхийн чадамжтай болон чадамжгүйд тооцогдох ёстой этгээд харьяат нь байгаа Хэлэлцэн тохирогч Талын шүүх эрх бүхий байна. Шүүх нь өөрийн улсын хууль тогтоомжийг хэрэглэнэ.
2. Хэрэв Хэлэлцэн тохирогч нэг Талын шүүх нь өөрийн нутаг дэвсгэрт амьдарч буй Хэлэлцэн тохирогч нөгөө Талын иргэнийг иргэний хязгаарлагдмал эрх зүйн эрхийн чадамжтай буюу чадамжгүйд тооцох нь үндэслэлтэй болохыг тогтоовол энэ тухайгаа уг этгээд харьяат нь байгаа Хэлэлцэн тохирогч нөгөө Талын холбогдох шүүхэд мэдэгдэнэ.
3. Хойшлуулашгүй тохиолдолд энэ зүйлийн 1 дэх хэсэгт дурдсан шүүх уг этгээдийг болон түүний эд хөрөнгийг хамгаалах талаар шаардлагатай арга хэмжээг авч болно. Ийнхүү арга хэмжээ авсан тухай мэдээллийг уг этгээд харьяат нь байгаа Хэлэлцэн тохирогч Талын холбогдох шүүхэд хүргүүлнэ.
4. Хэрэв энэ зүйлийн 2 дахь хэсгийн дагуу мэдээ хүлээн авсан Хэлэлцэн тохирогч нөгөө Талын шүүх нь цаашдын үйлдлийг уг этгээдийн оршин суугаа газрын шүүхээр гүйцэтгүүлэхээр болсон буюу, эсхүл гурван сарын хугацаанд түүнд мэдэгдээгүй бол тухайн этгээдийн оршин суугаа газрын шүүх нь иргэний хязгаарлагдмал эрх зүйн эрхийн чадамжтай буюу чадамжгүйд тооцох үндэслэлийг уг этгээдийн харьяат нь байгаа Хэлэлцэн тохирогч Талын хууль тогтоомжид нэгэн адил заасан бол түүнийг иргэний хязгаарлагдмал эрх зүйн эрхийн чадамжтай буюу чадамжгүйд тооцох хэргийг явуулж болно. Иргэний хязгаарлагдмал эрх зүйн эрхийн чадамжтай буюу чадамжгүйд тооцох тухай шийдвэрийг Хэлэлцэн тохирогч нөгөө Талын холбогдох шүүхэд хүргүүлнэ.
5. Энэхүү заалтыг иргэний эрх зүйн эрхийн чадамжийг хязгаарласныг өөрчлөх, эсхүл түүнийг иргэний эрх зүйн эрхийн чадамжтайд тооцоход нэгэн адил хэрэглэнэ.

21 дүгээр зүйл

Иргэнийг сураггүй алга болсон буюу нас барсанд тооцох

1. Иргэнийг сураггүй алга болсон буюу нас барсанд тооцох, түүнчлэн нас барсан үйл баримтыг тогтооход сүүлчийн мэдээгээр уг иргэн амьд ахуй цагтаа харьяат нь байсан Хэлэлцэн тохирогч Талын эрх бүхий шүүх өөрийн улсын хууль тогтоомжийн дагуу шийдвэрлэнэ.
2. Хэлэлцэн тохирогч нэг Талын шүүх өөрийн улсын хууль тогтоомжийн дагуу Хэлэлцэн тохирогч нөгөө Талын иргэнийг сураггүй алга болсон буюу нас барсанд тооцох, түүнчлэн нас барсан үйл баримтыг дараахь тохиолдолд тогтоож болно:
 - 1/шүүх нь шийдвэр гаргах ёстой Хэлэлцэн тохирогч Талын нутаг дэвсгэрт байгаа нас барсан буюу сураггүй алга болсон этгээдийн үл хөдлөх эд хөрөнгийн хувьд өвлөх эрх болон гэрлэгсдийн хоорондох эд хөрөнгийн харилцаанаас үүсэн гарч буй эрхээ хэрэгжүүлэхийг хүсч байгаа этгээдийн хүсэлтээр;
 - 2/шүүх нь шийдвэр гаргах ёстой Хэлэлцэн тохирогч Талын нутаг дэвсгэр дээр хүсэлт гаргах үедээ амьдарч байгаа, нас барсан буюу сураггүй алга болсон этгээдийн нөхөр /эхнэр/-ийн хүсэлтээр.
3. Энэ зүйлийн 2 дахь хэсгийн дагуу гаргасан шийдвэр нь зөвхөн шүүх нь уг шийдвэрийг гаргасан Хэлэлцэн тохирогч Талын нутаг дэвсгэр дээр хүчинтэй байна.

ХОЁРДУГААР БҮЛЭГ

ЭД ХӨРӨНГИЙН АСУУДАЛ

22 дугаар зүйл

Хэлцэлийн хэлбэр

1. Хэлцэлийн хэлбэрийг нутаг дэвсгэрт нь уг хэлцэл үйлдэгдсэн Хэлэлцэн тохирогч Талын хууль тогтоомжоор тодорхойлно.
2. Үл хөдлөх эд хөрөнгийн хэлцэлийн хэлбэрийг уг эд хөрөнгө нутаг дэвсгэрт нь байгаа Хэлэлцэн тохирогч Талын хууль тогтоомжоор тодорхойлно.

23 дугаар зүйл

Үл хөдлөх эд хөрөнгө

Үл хөдлөх эд хөрөнгөд хамаарах эрх зүйн харилцаанд уг эд хөрөнгө нутаг дэвсгэрт нь байгаа Хэлэлцэн тохирогч Талын байгууллага эрх бүхий байх бөгөөд тухайн улсын хууль тогтоомжийг хэрэглэнэ.

24 дүгээр зүйл

Гэрээний дагуу хүлээх үүрэг

1. Гэрээний дагуу хүлээх үүрэг нь зохигчдын сонгож авах улсын хууль тогтоомжоор тодорхойлогдоно. Хэрэв зохигчид нь хэрэглэхэд тохиромжтой хууль тогтоомжоо сонгоогүй бол тухайн гэрээний агуулгын хувьд шийдвэрлэх ач холбогдолтой биелэлтийг хэрэгжүүлж буй тал нутаг дэвсгэрт нь оршин суугаа, эсхүл үүсгэн байгуулагдсан болон эсхүл оршин байгаа Хэлэлцэн тохирогч Талын хууль тогтоомжийг хэрэглэнэ.
2. Үйлдвэр үүсгэн байгуулах тухай гэрээнд уг үйлдвэр нутаг дэвсгэрт нь байгуулагдах ёстой Хэлэлцэн тохирогч Талын эрх зүйг хэрэглэнэ.
3. Энэ зүйлийн 1 дэхь хэсэгт дурдсан асуудлаар хариуцагч нутаг дэвсгэрт нь оршин суугаа буюу оршин байгаа Хэлэлцэн тохирогч Талын шүүх эрх бүхий байна. Түүнчлэн нэхэмжлэгч нутаг дэвсгэрт нь оршин суугаа буюу оршин байгаа Хэлэлцэн тохирогч Талын шүүх нь маргааны объект буюу эсхүл хариуцагчийн эд хөрөнгө уг нутаг дэвсгэрт байгаа бол эрх бүхий байна. Өөртөө үүрэг хүлээсэн зохигчид энэ эрх мэдлийг хэлэлцээ хийх замаар өөрчилж болно.

25 дугаар зүйл

Гэм хор учруулснаас үүсэх үүрэг

1. Гэм хор учруулснаас үүсэх үүрэг нь гэм хорыг арилгуулах тухай шаардлагын үндэслэл болж буй нөхцөл байдал нутаг дэвсгэрт нь гарсан Хэлэлцэн тохирогч Талын хууль тогтоомжоор тодорхойлогдоно. Хэрэв нэхэмжлэгч болон хариуцагч Хэлэлцэн тохирогч нэг Талын иргэн бол Хэлэлцэн тохирогч энэ Талын хууль тогтоомжийг хэрэглэнэ.
2. Энэ зүйлийн 1 дэх хэсэгт дурьдсан асуудлаар гэм хорыг арилгуулах тухай шаардлагын үндэслэл болж буй нөхцөл байдал нутаг дэвсгэрт нь гарсан буюу, эсхүл хариуцагч нутаг дэвсгэрт нь оршин суугаа буюу оршин байгаа Хэлэлцэн тохирогч Талын шүүх эрх бүхий байна. Нэхэмжлэгч нутаг дэвсгэрт нь оршин суугаа буюу оршин байгаа Хэлэлцэн тохирогч Талын нутаг дэвсгэрт хариуцагчийн эд хөрөнгө байгаа бол Хэлэлцэн тохирогч энэ Талын шүүх эрх бүхий байна.

ГУРАВДУГААР БҮЛЭГ

ХӨДӨЛМӨРИЙН ЭРХ ЗҮЙН АСУУДАЛ

26 дугаар зүйл

Хөдөлмөрийн харилцааг зохицуулах хууль тогтоомж

1. Хөдөлмөрийн гэрээнд оролцогч талууд тэдний хөдөлмөрийн харилцааг зохицуулж буй хууль тогтоомжийг өөрсдөө сонгон авч болно.
2. Хэрэв хууль тогтоомжийг сонгоогүй бол хөдөлмөрийн гэрээ үүсэх, өөрчлөгдөх, дуусгавар болохыг болон түүнээс үүсэн гарч буй гомдлын шаардлагыг нутаг дэвсгэрт нь ажил гүйцэтгэж байгаа, гүйцэтгэсэн буюу гүйцэтгэх ёстой байсан Хэлэлцэн тохирогч Талын хууль тогтоомжоор зохицуулна. Хэрэв Хэлэлцэн тохирогч нэг Талын нутаг дэвсгэр дээр байгаа ажилтан Хэлэлцэн тохирогч нөгөө Талын нутаг дэвсгэрт байгаа үйлдвэртэй байгуулсан хөдөлмөрийн гэрээний үндсэн дээр ажил гүйцэтгэж буй бол хөдөлмөрийн гэрээ байгуулах, өөрчлөгдөх, дуусгавар болохыг болон түүнээс үүсэн гарах гомдлын шаардлагыг Хэлэлцэн тохирогч энэ Талын хууль тогтоомжоор зохицуулна.
3. Энэ зүйлийн 2 дахь хэсэгт дурдсан асуудлаар нутаг дэвсгэрт нь ажил гүйцэтгэж буй, гүйцэтгэсэн буюу гүйцэтгэх ёстой байсан Хэлэлцэн тохирогч Талын шүүх эрх бүхий байна. Түүнчлэн хариуцагч нутаг дэвсгэрт нь оршин суугаа буюу оршин байгаа, эсхүл нутаг дэвсгэрт нь нэхэмжлэгч оршин суугаа буюу оршин байгаа бөгөөд хэрэв уг нутаг дэвсгэрт маргааны эд зүйл болон хариуцагчийн эд хөрөнгө байгаа

бол Хэлэлцэн тохирогч Талын шүүх эрх бүхий байна. Энэхүү эрх мэдлийг хөдөлмөрийн гэрээнд оролцогч талууд хэлэлцээ хийх замаар өөрчилж болно.

ДӨРӨВДҮГЭЭР БҮЛЭГ ЗАРДАЛ БОЛОН БАЙЦААН ШИЙТГЭХ АЖИЛЛАГААНЫ ЯВЦАД ҮЗҮҮЛЭХ ХӨНГӨЛӨЛТИЙН ТУХАЙ ЗААЛТ

27 дугаар зүйл

Байцаан шийтгэх ажиллагаа явуулах зардлыг нөхөхөд барьцаанаас чөлөөлөх

Хэлэлцэн тохирогч нэг Талын шүүхэд хандаж буй Хэлэлцэн тохирогч нөгөө Талын иргэнээс гадаадын иргэн гэх буюу, эсхүл байгууллагад нь хандаж буй Хэлэлцэн тохирогч Талын нутаг дэвсгэрт оршин суудаггүй буюу амьдардаггүй гэсэн үндэслэлээр байцаан шийтгэх ажиллагаа явуулах зардлыг нөхөхөд барьцаа шаардаж болохгүй.

28 дугаар зүйл

Шүүхийн зардлаас чөлөөлөх

1. Хэлэлцэн тохирогч нэг Талын иргэн Хэлэлцэн тохирогч нөгөө Талын нутаг дэвсгэр дээр шүүхийн зардлаас чөлөөлөгдөх ба Хэлэлцэн тохирогч энэ Талын иргэний нэгэн адил нөхцөл, хэмжээнд байцаан шийтгэх ажиллагаанд үнэ төлбөргүй төлөөлөх эрхийг эдэлнэ.
2. Энэ зүйлийн 1 дэхь хэсэгт дурдсан хөнгөлөлт нь шийдвэр биелүүлэхийг оролцуулан уг хэргийн байцаан шийтгэх бүх ажиллагаанд хамаарна.
3. Хэлэлцэн тохирогч нэг Талын шүүхээс тодорхой хэргийг шүүхийн зардлаас чөлөөлөх нь Хэлэлцэн тохирогч нөгөө Талын нутаг дэвсгэрт энэ хэргийн талаарх байцаан шийтгэх ажиллагаа явуулахаар үүссэн зардалд нэгэн адил хамаарна.

29 дүгээр зүйл

Шүүхийн зардлаас чөлөөлөх үндэслэл

1. Шүүхийн зардлаас чөлөөлөх буюу байцаан шийтгэх ажиллагаанд үнэ төлбөргүй төлөөлөх тухай өргөдөл гаргагчийн хувийн, гэр бүлийн болон эд хөрөнгийн байдлын тухай тодорхойлолтыг гаргаж өгөх ёстой. Ийнхүү тодорхойлолтыг өргөдөл гаргагч нутаг дэвсгэрт нь оршин суугаа буюу оршин байгаа Хэлэлцэн тохирогч Талын эрх бүхий байгууллагаас олгоно.
2. Хэрэв өргөдөл гаргагч нь Хэлэлцэн тохирогч Талуудын нутаг дэвсгэрт оршин суудаггүй буюу оршин байдаггүй бол өргөдөл гаргагч харьяат нь байгаа Хэлэлцэн тохирогч Талын дипломат төлөөлөгчийн буюу консулын газраас тодорхойлолтыг олгож болно.
3. Шүүхийн зардлаас чөлөөлөх тухай шийдвэр гаргаж байгаа шүүх тодорхойлолт олгосон байгууллагаас нэмэлт тайлбар буюу мэдээллийг шаардаж болно.
4. Энэ зүйлийн 1 дэхь хэсэгт дурдсан тодорхойлолтыг Хэлэлцэн тохирогч Талын хууль тогтоомжийн дагуу заавал гаргах шаардлагагүй бол өргөдөл гаргагч нь өргөдөлдөө өөрийн эд хөрөнгийн болон гэр бүлийн байдлын талаар дурьдах ёстой.

30 дугаар зүйл

Шүүхийн зардлаас чөлөөлөх тухай хүсэлт

1. Шүүхийн зардлаас чөлөөлөх буюу байцаан шийтгэх ажиллагаанд үнэ төлбөргүй төлөөлөх тухай хүсэлтийг Хэлэлцэн тохирогч нөгөө Талын шүүхэд гаргах хүсэлтэй байгаа Хэлэлцэн тохирогч нэг Талын иргэн уг өргөдлийг өөрийн оршин суугаа буюу оршин байгаа газрын эрх бүхий шүүхийн протоколд тэмдэглүүлэх замаар амаар буюу бичгээр гаргаж болно. Энэ шүүх нь өргөдлийг 29 дүгээр зүйлд дурьдсан тодорхойлолтын хамт Хэлэлцэн тохирогч нөгөө Талын шүүхэд илгээнэ.
2. Энэ зүйлийн 1 дэх хэсэгт дурдсан хүсэлтийг хэрэг үүсгэх тухай өргөдөл буюу эсхүл нэхэмжлэлийн хамт гаргаж болно.

31 дүгээр зүйл

Шүүхийн зардал

Хэлэлцэн тохирогч нэг Талын шүүх Хэлэлцэн тохирогч нөгөө Талын нутаг дэвсгэрт оршин суугаа буюу оршин байгаа талд шүүхийн зардлыг төлөх буюу нэхэмжлэл, эсхүл өргөдлийн бүрдлийн дутууг гүйцээх үүрэг хүлээлгэх ба үүний тулд нэг сараас доошгүй хугацаа тогтооно. Хугацаа нь холбогдох мэдэгдлийг гардуулсан өдрөөс эхлэн тоологдоно.

32 дугаар зүйл

Хугацаа

1. Хэрэв Хэлэлцэн тохирогч нэг Талын шүүх Хэлэлцэн тохирогч нөгөө Талын нутаг дэвсгэрт оршин суугаа зохигчдод байцаан шийтгэх ажиллагаа явуулах хугацаа зааж өгсөн бол нутаг дэвсгэрээс нь шаардлага бүхий баримт бичгийг явуулсан Хэлэлцэн тохирогч Талын шуудангийн байгууллагын дарсан тэмдгээр хугацааг гэрчилнэ.
2. Хэлэлцэн тохирогч нөгөө Талын нутаг дэвсгэрээс тогтоосон хугацаанд шүүхээс шаардсан төлбөр болон урьдчилгааг шилжүүлэх тохиолдолд түүнийг уг зохигчид нутаг дэвсгэрт нь оршин сууж байгаа Хэлэлцэн тохирогч Талын банкинд оруулсан он, сар, өдрөөр хугацааг тогтоон гэрчилнэ.
3. Хугацаа зөрчсөний улмаас гарах үр дагаварт хэргийг хянан шийдвэрлэж буй шүүх өөрийн улсын хууль тогтоомжийг хэрэглэнэ.

ТАВДУГААР БҮЛЭГ ШИЙДВЭРИЙГ ХҮЛЭЭН ЗӨВШӨӨРӨХ, ГҮЙЦЭТГЭХ

33 дугаар зүйл

Эд хөрөнгийн бус шинжтэй хэргийн талаарх шүүхийн шийдвэрийг хүлээн зөвшөөрөх

1. Хэлэлцэн тохирогч нэг Талын шүүхийн гаргасан эд хөрөнгийн бус шинжтэй иргэний хэргийн талаарх хуулийн хүчин төгөлдөр болсон шийдвэр нь хэрэв Хэлэлцэн тохирогч нөгөө Талын шүүх уг хэргийн талаар хуулийн хүчин төгөлдөр болсон шийдвэр гаргаагүй, мөн энэхүү Гэрээний дагуу онцгой эрх хэмжээгүй бол Хэлэлцэн тохирогч нөгөө Талын нутаг дэвсгэрт тусгай ажиллагаа явуулахгүйгээр хүлээн зөвшөөрөгдөнө. Харин Гэрээнд ийм зохицуулалтыг тусгаагүй бол Хэлэлцэн тохирогч энэ Талын дотоодын хууль тогтоомжийн дагуу хүлээн зөвшөөрөгдөнө.
2. Хэлэлцэн тохирогч нэг Талын шүүхээс гадна бусад байгууллагаас гаргасан эд хөрөнгийн бус шинжтэй гэр бүлийн хэргийн талаарх шийдвэр нь энэ Гэрээний 35-37 дугаар зүйлийн заалтын дагуу Хэлэлцэн тохирогч нөгөө Талын нутаг дэвсгэрт хүлээн зөвшөөрөгдөнө. Эдгээр шийдвэр нь хүлээн зөвшөөрөгдөх тухай тусгай ажиллагаа явуулахгүйгээр хүлээн зөвшөөрөгдөж болно. Гэхдээ энэ нь нутаг дэвсгэрт нь хүлээн зөвшөөрөгдөх ёстой Хэлэлцэн тохирогч Талын хууль тогтоомжид нийцэж байгаа тохиолдолд хүлээн зөвшөөрөгдөнө.

34 дүгээр зүйл

Шийдвэрийг хүлээн зөвшөөрөх, гүйцэтгэх

1. Энэхүү Гэрээнд заасан нөхцөлийн дагуу Хэлэлцэн тохирогч Талууд өөрийн нутаг дэвсгэр дээр Хэлэлцэн тохирогч нөгөө Талын нутаг дэвсгэрт гаргасан дараахь шийдвэрийг хүлээн зөвшөөрч гүйцэтгэнэ:
 - 1/иргэний хэргийн талаарх шүүхийн шийдвэр;
 - 2/эрүүгийн хэргийн талаарх таслан шийдвэрлэх тогтоолын гэмт хэргийн улмаас учирсан хохирлыг нөхөн төлүүлэх хэсэг.
2. Энэ зүйлийн 1 дэх заалтын шүүхийн шийдвэр гэсэн ойлголтод эд хөрөнгийн шинжтэй иргэний хэргийн талаарх шүүхээр батлагдсан /магадлагдсан/ эвийн хэлэлцээ болон Хэлэлцэн тохирогч Талын хууль тогтоомжийн дагуу нутаг дэвсгэрт нь үйлдэгдсэн хүчин төгөлдөр бүхий гүйцэтгэх бичигтэй нотариатын актууд хамаарна.

35 дугаар зүйл

Шийдвэрийг хүлээн зөвшөөрөх ба гүйцэтгэх үндэслэл

Энэхүү гэрээний 34 дүгээр зүйлд дурдагдсан шийдвэрүүд Хэлэлцэн тохирогч нөгөө Талын нутаг дэвсгэрт дараахь тохиолдолд хүлээн зөвшөөрөгдөж гүйцэтгэгдэнэ. Хэрэв:

- 1/Хэлэлцэн тохирогч Талын хууль тогтоомжийн дагуу түүний нутаг дэвсгэрт нь шийдвэр гарсан ба хуулийн хүчин төгөлдөр болсон бол. Харин хүүхдийн тэтгэлгийн хэргийн талаарх шийдвэр нь хуулийн хүчин төгөлдөр болоогүй байсан ч нэн даруй гүйцэтгэгдэнэ;
- 2/энэ Гэрээний дагуу болон хэрэв тийм зохицуулалт нь Гэрээнд тусгаагүй үед шийдвэр нутаг дэвсгэрт нь хүлээн зөвшөөрөгдөх ба гүйцэтгэгдэх ёстой Хэлэлцэн тохирогч Талын хууль тогтоомжийн дагуу уг хэрэг нь тухайн Хэлэлцэн тохирогч Талын байгууллагын онцгой эрх хэмжээнд хамаарахгүй бол;
- 3/тухайн зохигчид нь өөрийн эрхийг хамгаалах боломжоо алдаагүй буюу эрх зүйн эрхийн чадамжийг нь хязгаарласан тохиолдолд зохих төлөөлөх эрхээ алдаагүй тухайлбал, шүүхээр хэргийн хянан хэлэлцэхэд оролцоогүй зохигчид шүүхийн зарлан дуудах хуудсыг цаг тухайд нь зохих жумаар авсан бол;

4/нутаг дэвсгэрт нь шийдвэр хүлээн зөвшөөрөгдөх ба гүйцэтгэгдэх ёстой Хэлэлцэн тохирогч Талын шүүх тухайн зохигчдын хоорондох тэр хэрэгт хуулийн хүчин төгөлдөр болсон шийдвэр гаргаагүй, нутаг дэвсгэрт нь шийдвэр хүлээн зөвшөөрөгдөх ба гүйцэтгэгдэх ёстой Хэлэлцэн тохирогч Талын шүүх урьд нь тухайн зохигчдын хооронд байцаан шийтгэх ажиллагааг эхлээгүй бол;

5/шийдвэр хүлээн зөвшөөрөгдөх ба гүйцэтгэгдэх ёстой Хэлэлцэн тохирогч Талын нутаг дэвсгэрт тухайн зохигчдын хоорондох тэр хэрэгт нь гаргасан гуравдагч улсын шүүхийн шийдвэр хүлээн зөвшөөрөгдөөгүй ба гүйцэтгэгдээгүй бол;

6/хэргийн талаар шийдвэр гаргахдаа Хэлэлцэн тохирогч нөгөө Талын хуулийг хэрэглэх ёстой байсныг хэрэглэсэн, эсхүл байгууллага нь шийдвэр гаргасан Хэлэлцэн тохирогч Талын хуулийг тухайн хэрэгт хэрэглэсэн нь зарчмын хувьд Хэлэлцэн тохирогч нөгөө Талын хуулиас ялгагдахгүй бол.

36 дугаар зүйл

Шийдвэрийг хүлээн зөвшөөрөх ба гүйцэтгэх тухай хүсэлт

1. Шийдвэрийг хүлээн зөвшөөрөх ба гүйцэтгэх тухай хүсэлтийг нутаг дэвсгэрт нь шийдвэр хүлээн зөвшөөрөгдөх ба гүйцэтгэгдэх ёстой Хэлэлцэн тохирогч Талын эрх бүхий шүүхэд шууд, эсхүл хэргийг хянан шийдвэрлэсэн анхан шатны шүүхээр дамжуулан гаргаж болно.
2. Хүсэлтэд дараахь зүйлийг хавсаргах шаардлагатай:
 - 1/шийдвэр буюу, эсхүл шийдвэр хуулийн хүчин төгөлдөр болсон ба гүйцэтгэвэл зохихыг баталсан түүний баталгаат хуулбар, хүүхдийн тэтгэлгийн тухай хэргийн хувьд хэрэв шийдвэр хуулийн хүчин төгөлдөр болоогүй бол түүнийг гүйцэтгэвэл зохих тухай баталгаа /хэрэв энэ тухай уг шийдвэрт заагаагүй бол/
 - 2/тухайн зохигчдын хувьд эсрэг шийдвэр гарсан болон шүүх хэргийг хэлэлцэхэд оролцоогүй зохигчид нутаг дэвсгэрт нь шийдвэр гарсан Хэлэлцэн тохирогч Талын хууль тогтоомжийн дагуу шүүхийн зарлан дуудах хуудсыг цаг тухайд нь зохих журмаар авсан бол үүнийг баталсан баримт бичиг, харин тухайн зохигчид хэрэв хязгаарлагдмал эрх зүйн эрхийн чадамжтай бол энэ талд зохих журмаар мэдэгдсэнийг баталсан баримт бичиг;
 - 3/хүсэлт, түүнчлэн энэ зүйлийн 1, 2 дахь заалтад дурдсан баримт бичгийн нутаг дэвсгэрт нь шийдвэр хүлээн зөвшөөрөгдөх ба гүйцэтгэгдэх ёстой Хэлэлцэн тохирогч Талын хэл дээрх баталгаат орчуулга.

37 дугаар зүйл

Шийдвэрийг хүлээн зөвшөөрөх ба гүйцэтгэх журам

1. Шийдвэрийг хүлээн зөвшөөрөх ба гүйцэтгэхэд нутаг дэвсгэрт нь шийдвэр хүлээн зөвшөөрөгдөх ба гүйцэтгэгдэх ёстой Хэлэлцэн тохирогч Талын шүүх эрх бүхий байна.
2. Шүүх нь шийдвэрийг хүлээн зөвшөөрөх ба гүйцэтгэх талаарх байцаан шийтгэх ажиллагааг энэхүү Гэрээний 35, 36 дугаар зүйлд заасан нөхцөл биелэгдсэнээр хязгаарлана.
3. Шийдвэрийг хүлээн зөвшөөрөх ба гүйцэтгэхэд нутаг дэвсгэрт нь шийдвэр хүлээн зөвшөөрөгдөх ба гүйцэтгэгдэх ёстой Хэлэлцэн тохирогч Талын хууль тогтоомжийг хэрэглэнэ. Энэ нь шийдвэрийг хүлээн зөвшөөрөх ба гүйцэтгэх тухай хүсэлтийн хэлбэрт хамаарна.
4. Хэрэв шүүх нь шийдвэр гаргасан Хэлэлцэн тохирогч Талын нутаг дэвсгэрт шийдвэр гүйцэтгэхийг зогсоосон бол Хэлэлцэн тохирогч нөгөө Талын нутаг дэвсгэрт шийдвэрийг хүлээн зөвшөөрөх ба гүйцэтгэх талаарх байцаан шийтгэх ажиллагааг зогсоох бөгөөд хэрэв албадан гүйцэтгэх тухай байцаан шийтгэх ажиллагаа явуулж байгаа бол уг ажиллагааг мөн зогсооно.
5. Шүүх нь шийдвэрийг хүлээн зөвшөөрөх ба гүйцэтгэх тухай шийдвэр гаргахдаа зохигчдоос нэмэлт тайлбар шаардаж болно. Түүнчлэн шүүх нь шийдвэр гаргасан шүүхээс тайлбар шаардаж болно.

38 дугаар зүйл

Зардлын талаарх шийдвэрийг гүйцэтгэх

1. Хэрэв нэг Тал нь энэ Гэрээний 27 дугаар зүйлийн үндсэн дээр байцаан шийтгэх ажиллагаа явуулах зардлыг хангах барьцаа өгөөгүй болон хуулийн хүчин төгөлдөр болсон шүүхийн шийдвэрээр энэ зардлыг төлөх үүрэгтэй бол Хэлэлцэн тохирогч нөгөө Талын эрх бүхий шүүх зардлыг гаргуулах тухай шийдвэрийг албадан гүйцэтгэх ийм эрхтэй Талын хүсэлтийн дагуу үнэ төлбөргүй зөвшөөрнө.
2. Байцаан шийтгэх ажиллагаа явуулах зардал гэдэгт шийдвэр хуулийн хүчин төгөлдөр болж буйг гэрчлэхтэй болон шийдвэрийг гүйцэтгэвэл зохих баталгаатай холбогдсон зардал, түүнчлэн хүсэлт буюу шаардсан баримт бичгийг шилжүүлэх талаарх зардал хамаарна.
3. Зардлын талаарх шийдвэрийг гүйцэтгэх тухай асуудлыг хэрэг хянан шийдвэрлэж буй шүүх нь шийдвэр хуулийн хүчин төгөлдөр болсныг болон гүйцэтгэвэл зохихыг тогтоосноор хязгаарлана.

4. Шийдвэрийг гүйцэтгэх тухай хүсэлтэд шийдвэр хуулийн хүчин төгөлдөр болсон буюу түүнийг гүйцэтгэвэл зохих баталгаа бүхий шийдвэрийн зардлын хэмжээг тогтоосон хэсгийн баталгаат хуулбар, түүнчлэн хүсэлтийн болон уг баримт бичгийн баталгаат орчуулгыг хавсаргана.
5. Нутаг дэвсгэрт нь байцаан шийтгэх ажиллагаа явуулах зардлыг улсаас урьдчилгаа болгож олгосон Хэлэлцэн тохирогч Талын шүүх Хэлэлцэн тохирогч нөгөө Талын эрх бүхий шүүхэд уг зардлыг нөхөн төлүүлэх тухай хүсэлтээ гаргаж болно. Энэхүү шүүх нь өөрийн улсын хууль тогтоомжийн дагуу уг зардлыг нөхөн төлүүлэх ажлыг үнэ төлбөргүйгээр хийх бөгөөд нөхөн гаргуулсан мөнгийг Хэлэлцэн тохирогч нөгөө Талын дипломат төлөөлөгчийн буюу консулын газарт шилжүүлнэ. Энэ тохиолдолд энэ зүйлийн 1, 2 дахь хэсгийг хэрэглэнэ.

Гуравдугаар хэсэг ЭРҮҮГИЙН ХЭРЭГ

НЭГДҮГЭЭР БҮЛЭГ ЭРҮҮГИЙН БАЙЦААН ШИЙТГЭХ АЖИЛЛАГАА ЯВУУЛАХ

39 дүгээр зүйл

Эрүүгийн байцаан шийтгэх ажиллагаа явуулах үүрэг

1. Хэлэлцэн тохирогч Тал бүр даалгавар өгсөн Хэлэлцэн тохирогч нөгөө Талын нутаг дэвсгэрт гэмт хэрэг үйлдсэн гэж сэжиглэгдэж байгаа өөрийн иргэний хувьд Хэлэлцэн тохирогч нөгөө Талын хүсэлтээр хууль тогтоомжийнхоо дагуу эрүүгийн байцаан шийтгэх ажиллагаа явуулах үүрэг хүлээнэ.
2. Хэрэв эрүүгийн хэрэг үүсгэхтэй холбогдсон үйлдэл нь хохирлыг нөхөн төлүүлэх тухай гомдлын шаардлагыг агуулсан бөгөөд хохирлыг нөхөн төлүүлэх тухай зохих хүсэлт гаргасан бол тэдгээрийг уг эрүүгийн хэрэгт хамтатган авч үзнэ.
3. Хэлэлцэн тохирогч Тал бүр хүсэлт өгсөн Хэлэлцэн тохирогч нөгөө Талын нутаг дэвсгэрт ял шийтгэгдэх хэрэг үйлдсэн гэж сэжиглэгдэж байгаа болон эрүүгийн хариуцлага хүлээх насанд хүрээгүй өөрийн улсын иргэний буюу нутаг дэвсгэрт нь байнга оршин сууж байгаа этгээдийн хувьд Хэлэлцэн тохирогч нөгөө Талын хүсэлтээр өөрийн улсын хууль тогтоомжийн дагуу материалыг хүлээн авах, хянан шийдвэрлэх үүрэг хүлээнэ.

40 дүгээр зүйл

Эрүүгийн байцаан шийтгэх ажиллагаа явуулах тухай хүсэлт

1. Эрүүгийн байцаан шийтгэх ажиллагаа явуулах тухай хүсэлт нь дараахь зүйлийг агуулсан байна:
 - 1/хүсэлт өгсөн байгууллагын нэр;
 - 2/сэжиглэгдэж буй этгээдийн овог нэр, иргэний харьяалал, оршин суугаа буюу оршин байгаа газар, уг хүний талаарх аль болох дэлгэрэнгүй мэдээ;
 - 3/хэрэг үйлдсэний улмаас үүссэн үр дагавар болон учирсан хохирлыг заасан эрүүгийн байцаан шийтгэх ажиллагаа явуулах тухай хүсэлт явуулж байгаатай холбогдох хэргийн тодорхойлолт ба хуулийн зүйлчлэл.
2. Хүсэлтэд дараахь зүйлийг хавсаргана:
 - 1/эрүүгийн хуулийн хэм хэмжээ, шаардлагатай бол эрүүгийн байцаан шийтгэх ажиллагаа явуулахад ач холбогдол бүхий хүсэлт өгсөн Хэлэлцэн тохирогч Талын хуулийн бусад заалт;
 - 2/хэргийн материал, эсхүл түүний баталгаат хуулбар, түүнчлэн нотлох баримт;
 - 3/хохирлыг нөхөн төлүүлэх тухай хүсэлт ба боломжийн хэрээр хохирлын хэмжээний талаарх мэдээлэл;
 - 4/хэрэв хүсэлт хүлээн авсан Хэлэлцэн тохирогч Талын хууль тогтоомж үүнийг шаардаж байгаа бол байцаан шийтгэх ажиллагаа явуулах тухай хохирогчийн өргөдөл.

41 дүгээр зүйл

Сэжигтэн этгээдийг шилжүүлэх

1. Хэрэв эрүүгийн байцаан шийтгэх ажиллагаа явуулах тухай хүсэлтийг илгээх үед сэжигтэн этгээд нь даалгавар өгсөн Хэлэлцэн тохирогч Талын нутаг дэвсгэрт цагдан хоригдож байвал түүнийг хүсэлт хүлээн авсан Хэлэлцэн тохирогч Талд шилжүүлэх арга хэмжээг хангасан байна.
2. Хэрэв эрүүгийн байцаан шийтгэх ажиллагаа явуулах тухай хүсэлтийг илгээх үед сэжигтэн этгээд нь хүсэлт өгсөн Хэлэлцэн тохирогч Талын нутаг дэвсгэр дээр гадуур сул чөлөөтэй явж байвал энэ Тал нь өөрийн улсын хууль тогтоомжийн дагуу уг этгээдийг хүсэлт хүлээн авсан Хэлэлцэн тохирогч Талд буцаах арга хэмжээ авах ёстой.

42 дугаар зүйл

Эрүүгийн байцаан шийтгэх ажиллагааны үр дүнгийн тухай мэдээлэх

Хүсэлт хүлээн авсан Хэлэлцэн тохирогч Тал хэргийн талаарх эцсийн шийдвэрээ хүсэлт өгсөн Хэлэлцэн тохирогч Талд мэдээлнэ. Энэхүү шийдвэрийн хуулбарыг хүсэлт өгсөн Хэлэлцэн тохирогч Талын хүсэлтээр хүргүүлнэ.

43 дугаар зүйл

Эрүүгийн байцаан шийтгэх ажиллагаа явуулсны үр дагавар

Хэрэв хүсэлт хүлээн авсан Хэлэлцэн тохирогч Тал нь байцаан шийтгэх ажиллагааг үүсгэх буюу дуусгавар болгохоос татгалзаж буй тухайгаа хүсэлт өгсөн Хэлэлцэн тохирогч Талд мэдэгдсэн тохиолдолд тэр Тал нь эрүүгийн байцаан шийтгэх ажиллагаа явуулах тухай хүсэлтдээ хэргийг сэргээж болох тухай дурьдаагүй бол түүний эрх бүхий байгууллага нь тухайн хэрэгт тухайн этгээдийн хувьд хүсэлт хүлээн авсан Хэлэлцэн тохирогч Талаас эрүүгийн байцаан шийтгэх ажиллагаа авч хэрэгжүүлж эхэлснээс хойш байцаан шийтгэх ажиллагаа явуулж болохгүй.

ХОЁРДУГААР БҮЛЭГ ЭРҮҮГИЙН БАЙЦААН ШИЙТГЭХ АЖИЛЛАГАА ЯВУУЛАХ БУЮУ ТАСЛАН ШИЙДВЭРЛЭХ ТОГТООЛЫГ ГҮЙЦЭТГЭХЭЭР ШИЛЖҮҮЛЭН ӨГӨХ

44 дүгээр зүйл

Гэмт этгээдийг шилжүүлэн өгөх

1. Хэлэлцэн тохирогч хоёр Тал энэхүү Гэрээний заалтын дагуу өөрийн нутаг дэвсгэрт байгаа этгээдийг эрүүгийн байцаан шийтгэх ажиллагаа явуулах буюу таслан шийдвэрлэх тогтоолыг гүйцэтгэхээр харилцан шаардсаны дагуу шилжүүлэн өгнө.
2. Хэлэлцэн тохирогч хоёр Талын хууль тогтоомжоор гэмт хэрэг гэж үзэх хэрэг үйлдсэн бөгөөд нэг жилээс дээш хугацаагаар хорих буюу өөр хүнд ял оногдуулах хэрэгт эрүүгийн байцаан шийтгэх ажиллагаа явуулахаар шилжүүлэн өгнө.
3. Хэлэлцэн тохирогч хоёр Талын хуулиар гэмт хэрэг гэж үзэх хэрэг үйлдсэн бөгөөд хэрэв энэ үед шилжүүлэн өгөхийг шаардсан этгээд нь зургаан сараас доошгүй хугацаагаар хоригдох буюу өөр хүнд ял шийтгэгдсэн бол таслан шийдвэрлэх тогтоолыг гүйцэтгэхээр шилжүүлэн өгнө.

45 дугаар зүйл

Шилжүүлэн өгөхөөс татгалзах

1. Дараахь тохиолдолд шилжүүлэн өгөхгүй. Хэрэв:
 - 1/шилжүүлэн өгөхийг шаардсан этгээд нь шаардлага хүлээн авсан Хэлэлцэн тохирогч Талын иргэн бол;
 - 2/шаардлага хүлээн авсан Хэлэлцэн тохирогч Талын хууль тогтоомжийн дагуу хөөн хэлэлцэх хугацаа дууссан буюу хуульд заасан бусад үндэслэлээр эрүүгийн байцаан шийтгэх ажиллагаа явуулах буюу таслан шийдвэрлэх тогтоолыг гүйцэтгэж болохгүй болсон бол;
 - 3/шаардлага хүлээн авсан Хэлэлцэн тохирогч Талын нутаг дэвсгэрт шилжүүлэн өгөхийг шаардсан этгээдийн хувьд тэр гэмт хэрэгт нь хуулийн хүчин төгөлдөр болсон шийдвэр гаргасан, эсхүл хэргийг хэрэгсэхгүй болгосон тухай тогтоол гарсан бол;
 - 4/эрүүгийн байцаан шийтгэх ажиллагаа нь хувийн гомдлоор үүссэн бол;
 - 5/шаардлага хүлээн авсан Хэлэлцэн тохирогч Талын хууль тогтоомжийн дагуу шилжүүлэн өгөхийг хориглосон бол.
2. Шилжүүлэн өгөхөөс дараахь тохиолдолд татгалзаж болно. Хэрэв:
 - 1/гэмт хэрэг нь шаардлага хүлээн авсан Хэлэлцэн тохирогч Талын нутаг дэвсгэрт үйлдэгдсэн бол;
 - 2/шаардлага хүлээн авсан Хэлэлцэн тохирогч Талын нутаг дэвсгэрт шилжүүлэн өгөхийг шаардсан этгээдийн талаар тэр гэмт хэрэгт нь эрүүгийн байцаан шийтгэх ажиллагаа явуулж байгаа бол.
3. Энэхүү зүйлийн 1 дэх хэсэгт заасны дагуу татгалзсан тохиолдолд шаардлага хүлээн авсан Хэлэлцэн тохирогч Тал шаардлага өгсөн Хэлэлцэн тохирогч Талын хүсэлтийн дагуу шилжүүлэн өгөхөөс татгалзсан этгээдийн хувьд эрүүгийн байцаан шийтгэх ажиллагааг өөрийн хууль тогтоомжийн дагуу үүсгэнэ. Энэ зорилгоор шаардлага өгсөн Хэлэлцэн тохирогч Тал шаардлага хүлээн авсан Хэлэлцэн тохирогч Талд өөрийн мэдэлд байгаа материал болон нотлох баримтыг шилжүүлнэ.
4. Шаардлага хүлээн авсан Хэлэлцэн тохирогч Тал нь энэ зүйлийн 2 дахь хэсгийн 2-г заасны дагуу татгалзсан тохиолдолд эрүүгийн байцаан шийтгэх ажиллагаа үүсгэхээр уг хэргийг шийдвэрлэх өөрийн

эрх бүхий байгууллагад шилжүүлнэ. Уг эрх бүхий байгууллагаас эрүүгийн байцаан шийтгэх ажиллагаа үүсгэхгүй тухай хүсэлтийг энэхүү Гэрээний нийтлэг журмын дагуу дахин шийдвэрлэнэ.

46 дугаар зүйл

Шилжүүлэн өгөх тухай шаардлага

1. Шилжүүлэн өгөх тухай шаардлага нь дараахь зүйлийг агуулсан байна. Үүнд:
 - 1/шаардлага өгсөн байгууллагын нэр;
 - 2/шилжүүлэн өгөхийг шаардсан этгээдийн овог, нэр, иргэний харьяалал, оршин суугаа буюу оршин байгаа газрын тухай мэдээ болон хувийн байдлын талаарх бусад мэдээлэл, түүнчлэн бололцоотой бол түүний гэрэл зураг, хурууны хээг хавсаргасан гаднах төрх байдлын тухай тодорхойлолт;
 - 3/үйлдэгдсэн гэмт хэргийн тодорхойлолт ба хэргийн эрх зүйн ангилал;
 - 4/учирсан эд хөрөнгийн хохирлын хэмжээний тухай мэдээ.
2. Эрүүгийн байцаан шийтгэх ажиллагаа явуулахаар шилжүүлэн өгөх тухай шаардлагад гэмт хэргийн тодорхойлолт бүхий цагдан хорих тухай тогтоолын баталгаат хуулбар, түүнчлэн шилжүүлэн өгөхийг шаардсан этгээдийн үйлдсэн хэрэгт хамаарах хуулийн заалтыг хавсаргасан байна.
3. Таслан шийдвэрлэх тогтоолыг гүйцэтгэхээр шилжүүлэн өгөх тухай шаардлагад хуулийн хүчин төгөлдөр болсон таслан шийдвэрлэх тогтоолын баталгаат хуулбар болон таслан шийдвэрлэх тогтоол гарах үндэслэл болсон хуулийн заалтыг хавсаргасан байна.
Хэрэв ялтан этгээд ял эдэлж эхэлсэн бол ялын эдэлсэн хугацааг заасан байна.

47 дугаар зүйл

Шилжүүлэн өгөх тухай шаардлагын нэмэлт мэдээ

Хэрэв шилжүүлэн өгөх тухай шийдвэр гаргахад хүлээн авсан мэдээ нь хангалттай бус бол шаардлага хүлээн авсан Хэлэлцэн тохирогч Тал нэмэлт мэдээ шаардаж болох ба үүний тулд нэг сар хүртэлх хугацаа тогтоож өгнө. Хүндэтгэн үзэх шалтгаантай бол энэ хугацааг сунгаж болно.

48 дугаар зүйл

Шилжүүлэн өгөх зорилгоор баривчлах

1. Шаардлага хүлээн авсан Хэлэлцэн тохирогч Тал шилжүүлэн өгөх тухай шаардлагыг хүлээн авмагц энэхүү Гэрээний дагуу шилжүүлэн өгөхгүй байх тохиолдлоос бусад үед шилжүүлэн өгөхийг шаардсан этгээдийг баривчлах арга хэмжээг өөрийн улсын хууль тогтоомжийн дагуу нэн даруй авах ёстой.
2. Хойшлуулшгүй тохиолдлын үед шаардлага хүлээн авсан Хэлэлцэн тохирогч Тал шилжүүлэн өгөх тухай шаардлагын үндэс болсон баривчлах тухай буюу хуулийн хүчин төгөлдөр болсон таслан шийдвэрлэх тогтоол гарсныг мэдэгдэн шилжүүлэн өгөхийг шаардвал уг этгээдийг шилжүүлэн өгөх тухай шаардлага хүлээн авахаас өмнө баривчилж болно. Баривчлах тухай шаардлагыг шуудан, цахилгаан, факс буюу бусад хэрэгслээр хүргүүлж болно.
3. Хэлэлцэн тохирогч аль ч Талын эрх бүхий хуулийн байгууллага нь өөрийн нутаг дэвсгэр дээр байгаа этгээдийг Хэлэлцэн тохирогч нөгөө Талын нутаг дэвсгэрт шилжүүлэн өгөхөөр заасан гэмт хэрэг үйлдсэн гэж сэжиглэх бүрэн үндэслэлтэй байвал энэ зүйлийн 2 дахь хэсэгт дурдсан шаардлагыг хүлээн авахгүйгээр түүнийг баривчлах, хорих тухай шийдвэр гаргаж болно.
4. Энэ зүйлийн 2, 3 дахь хэсэгт заасны дагуу баривчилсан тухай Хэлэлцэн тохирогч нөгөө Талд нэн даруй мэдэгдэнэ.
5. Энэхүү зүйлийн дагуу цагдан хоригдсон этгээдийн цагдан хоригдсон хугацааг шилжүүлэн авсан Хэлэлцэн тохирогч Талын хууль тогтоомжид заасан бол нийт цагдан хоригдсон хугацаанд оруулж тооцно.

49 дүгээр зүйл

Баривчлагдсан этгээдийг суллах

1. Шилжүүлэн өгөх тухай шаардлага хүлээн авсан Хэлэлцэн тохирогч Тал хэрэв энэ зүйлд дурдсан хугацаанд энэ Талын шаардсан нэмэлт мэдээг ирүүлээгүй бол 48 дугаар зүйлийн дагуу баривчлагдсан этгээдийг суллаж болно. Энэ тохиолдолд цагдан хоригдсон этгээдийг суллах талаар хүсэлт өгсөн Хэлэлцэн тохирогч Талд мэдэгдсэн байх ёстой.
2. Хэлэлцэн тохирогч нөгөө Талд уг этгээдийг баривчлагдсан тухай мэдэгдсэнээс хойш нэг сарын дотор түүнийг шилжүүлэн авах тухай шаардлага ирүүлээгүй бол 48 дугаар зүйлийн 2, 3 дахь хэсэгт заасны дагуу баривчлагдсан этгээдийг суллана.

50 дугаар зүйл
Шилжүүлэн өгөхийг хойшлуулах

Хэрэв шилжүүлэн өгөхийг шаардсан этгээд нь эрүүгийн хариуцлагад татагдсан буюу, эсхүл шаардлага хүлээн авсан Хэлэлцэн тохирогч Талын нутаг дэвсгэрт өөр гэмт хэргийн учир ял шийтгүүлсэн бол түүнийг эрүүгийн байцаан шийтгэх ажиллагаа явуулж дуусгах, эсхүл оногдуулсан ялыг эдэлж дуусах буюу хугацаанаас нь өмнө ял эдлэхээс суллах хүртэл шилжүүлэн өгөхийг хойшлуулж болно.

51 дүгээр зүйл
Түр шилжүүлэн өгөх

1. Хэрэв 50 дугаар зүйлд дурдсан шилжүүлэн өгөхийг хойшлуулах нь эрүүгийн байцаан шийтгэх ажиллагааны хөөн хэлэлцэх хугацаа дуусахаар буюу гэмт хэргийн байцаан шийтгэх ажиллагаанд ноцтой бэрхшээл учруулахаар байвал шилжүүлэн өгвөл зохих этгээдийг үндэслэл бүхий хүсэлтээр түр шилжүүлэн өгч болно.
2. Түр шилжүүлэн өгсөн этгээдийг байцаан шийтгэх ажиллагаа дууссаны дараа нэн даруй, гэхдээ түр шилжүүлэн өгсөн өдрөөс эхлэн гурван сараас хэтрэхгүй хугацаанд буцаан шилжүүлэн өгөх ёстой. Үндэслэл бүхий тохиолдолд энэ хугацааг шаардлага хүлээн авсан Хэлэлцэн тохирогч Тал сунгаж болно.

52 дугаар зүйл
Шилжүүлэн өгөх тухай шаардлагаас үүсэх зөрчилдөөн

Хэрэв нэг этгээдийг шилжүүлэн өгөхийг хэд хэдэн улс шаардаж байгаа бол шаардлага хүлээн авсан Хэлэлцэн тохирогч Тал тухайн этгээдийг аль улсад шилжүүлэн өгөхөө шийдвэрлэнэ. Ийм шийдвэр гаргах үед бүх нөхцөл байдал, тухайлбал, тухайн этгээдийн иргэний харьяалал, гэмт хэргийг үйлдсэн газар болон түүний шинж чанарыг анхааран үзнэ.

53 дугаар зүйл
Шилжүүлэн өгсөн этгээдийг эрүүгийн байцаан шийтгэх хязгаар

1. Шилжүүлэн өгсөн этгээдийг шилжүүлэн өгсөн Хэлэлцэн тохирогч Талын зөвшөөрөлгүйгээр эрүүгийн хариуцлагад татах, ял шийтгэх, түүнчлэн шилжүүлэн өгөхөөс өмнө үйлдсэн өөр хэрэгт нь гуравдагч улсад шилжүүлэн өгч болохгүй.
2. Шилжүүлэн өгсөн Хэлэлцэн тохирогч Талын зөвшөөрлийг дараахь тохиолдолд шаардахгүй. Хэрэв:

1/шилжүүлэн өгсөн этгээд нь эрүүгийн байцаан шийтгэх ажиллагаа буюу ял эдэлж дууссан өдрөөс хойш нэг сарын дотор Хэлэлцэн тохирогч Талын нутаг дэвсгэрээс гарч яваагүй бол. Шилжүүлэн өгсөн этгээд шаардлага өгсөн Хэлэлцэн тохирогч Талын нутаг дэвсгэрээс гарч явж чадаагүй нь түүний буруугаас болоогүй бол тэр хугацааг нь дээрх хугацаанд оруулан тооцохгүй.

2/шилжүүлэн өгсөн этгээд нь шаардлага өгсөн Хэлэлцэн тохирогч Талын нутаг дэвсгэрээс гарч явсан боловч тухайн нутаг дэвсгэрт сайн дураар буцаж ирсэн бол.

54 дүгээр зүйл
Шилжүүлэх

Шаардлага хүлээн авсан Хэлэлцэн тохирогч Тал уг этгээдийг шилжүүлэн өгөх газар, цаг хугацааг хүсэлт өгсөн Хэлэлцэн тохирогч Талд мэдэгдэнэ. Хэрэв шилжүүлэн өгөх этгээдийг хүсэлт өгсөн Хэлэлцэн тохирогч Тал нь шилжүүлэн өгөхөөр тогтоосон хугацаанаас хойш арван таван хоногийн дотор хүлээн авахгүй бол уг этгээдийг суллаж болно.

55 дугаар зүйл
Дахин шилжүүлэн өгөх

Шилжүүлэн өгсөн этгээд эрүүгийн байцаан шийтгэх ажиллагаа буюу ял эдлэхээс зайлсхийн шаардлага хүлээн авсан Хэлэлцэн тохирогч Талын нутаг дэвсгэрт буцаж ирвэл дахин шаардсаны дагуу 46 дугаар зүйлд заасан баримт бичгийг илгээхгүйгээр уг этгээдийг шилжүүлэн өгнө.

56 дугаар зүйл.
Эрүүгийн байцаан шийтгэх ажиллагааны
дүнгийн тухай мэдээлэх

Шаардлага өгсөн Хэлэлцэн тохирогч Тал шилжүүлэн өгсөн этгээдийн талаар явуулсан байцаан шийтгэх ажиллагааны дүнгийн тухай шаардлага хүлээн авсан Хэлэлцэн тохирогч Талд нэн даруй мэдээлэх бөгөөд хүсэлтийн дагуу хэргийн талаарх эцсийн шийдвэрийн хуулбарыг хүргүүлнэ.

57 дугаар зүйл
Дамжин өнгөрүүлэх

1. Хэлэлцэн тохирогч Тал бүр Хэлэлцэн тохирогч нөгөө Талын шаардлагын дагуу гуравдагч улсаас шаардлага өгсөн Хэлэлцэн тохирогч Талд шилжүүлэн өгөх этгээдийг өөрийн нутаг дэвсгэрээр дамжин өнгөрүүлэх зөвшөөрөл өгнө.
Хэрэв энэ Гэрээний дагуу шилжүүлэн өгөх үүрэггүй бол шаардлага хүлээн авсан Хэлэлцэн тохирогч Тал зөвшөөрөл өгөхгүй байж болно.
2. Дамжин өнгөрүүлэх тухай шаардлагыг шилжүүлэн өгөх тухай шаардлагатай адил журмаар хүргүүлэх ба хянан хэлэлцэнэ.
3. Шаардлага хүлээн авсан Хэлэлцэн тохирогч Тал нь өөртөө илүү тохиромжтой аргаар дамжин өнгөрүүлнэ.

58 дугаар зүйл
Шилжүүлэн өгөх болон дамжуулан өнгөрүүлэхтэй
холбогдсон зардал

Шилжүүлэн өгөхтэй холбогдсон зардлыг уг зардал нутаг дэвсгэрт нь гарсан Хэлэлцэн тохирогч Тал хариуцна. Дамжуулан өнгөрүүлэхтэй холбогдсон зардлыг шаардлага өгсөн Хэлэлцэн тохирогч Тал хариуцна.

ГУРАВДУГААР БҮЛЭГ
ЭРҮҮГИЙН ХЭРГИЙН ТАЛААРХ ЭРХ ЗҮЙН ТУСЛАЛЦААНД ХАМААРАХ
ТУСГАЙ ЗААЛТ

59 дүгээр зүйл
Хорих ял шийтгэгдсэн этгээдийг түр шилжүүлэх

1. Хэрэв шаардлага хүлээн авсан Хэлэлцэн тохирогч Талын нутаг дэвсгэрт хорих ял шийтгэгдсэн этгээдийг гэрчээр байцаах зайлшгүй шаардлага гарвал энэ Талын эрх бүхий бйгууллага түүнийг шаардлага өгсөн Хэлэлцэн тохирогч Талын нутаг дэвсгэрт хүргүүлэх тухай захирамж өгнө. Уг этгээдийг цагдан хорих бөгөөд байцаалтын дараа нэн даруй буцааж шилжүүлнэ.
2. Гуравдагч улсын нутаг дэвсгэр дээр хорих ял шийтгэгдсэн этгээдийг гэрчээр байцаах зайлшгүй шаардлагатай бол шаардлага хүлээн авсан Хэлэлцэн тохирогч Талын эрх бүхий байгууллага түүнийг өөрийн нутаг дэвсгэрээр дамжин өнгөрүүлэхийг зөвшөөрнө.

60 дугаар зүйл
Эд зүйлийг шилжүүлэх

1. Хэлэлцэн тохирогч Талуудын эрх бүхий байгууллагууд бие биенийхээ шаардлагын дагуу гэмт хэрэг үйлдэхэд ашигласан эд зүйл гэмт хэргийн үр дүнд, эсхүл түүнийг солих замаар олсон буюу түүнийг үйлдсэний учир авсан шагнал болон шаардлага өгсөн Хэлэлцэн тохирогч Талын нутаг дэвсгэрт явагдаж байгаа эрүүгийн байцаан шийтгэх ажиллагаанд эд мөрийн нотлох баримт болох бусад эд зүйлийг харилцан шилжүүлэх үүрэг хүлээнэ.
Эд зүйл гэдэгт мөнгө болон үнэт цаас хамаарна.
2. Шаардлага хүлээн авсан Хэлэлцэн тохирогч Тал хэрэв уг эд зүйл нь өөр эрүүгийн байцаан шийтгэх ажиллагаанд шаардлагатай бол түүнийг шилжүүлэхийг хойшлуулах буюу түр шилжүүлэн өгч болно.
3. Шилжүүлэн өгөх эд зүйлийн хувьд гуравдагч этгээдийн эрх халдашгүй хэвээр үлдэнэ.
Эрүүгийн байцаан шийтгэх ажиллагаа дууссаны дараа уг эд зүйлийг түүнийг шилжүүлсэн хэлэлцэн тохирогч Талд, эсхүл түүний зөвшөөрлөөр эрх бүхий этгээдэд буцаан өгнө.
4. Энэ зүйлийн дагуу эд зүйлийг шилжүүлэхэд тухайн эд зүйлийг оруулах, гаргахыг хязгаарласан Хэлэлцэн тохирогч хоёр Талын хууль тогтоомжийн заалтыг хэрэглэхгүй.
5. Хэрэв эрүүгийн байцаан шийтгэх ажиллагаа явуулахаар гэмт этгээдийг шилжүүлэн өгөхийг зөвшөөрвөл эд зүйлийг боломжтой бол уг этгээдтэй хамт шилжүүлэн өгнө. Шилжүүлэн өгөх талаар зөвшилцөөнд хүрсэн этгээдийг нас барсан буюу оргосны улмаас шилжүүлэн өгөх боломжгүй болсон үед ч эд зүйлийг шилжүүлнэ.

61 дүгээр зүйл
Эрх зүйн туслалцаа үзүүлэх үед хэлэлцэн тохирогч
хоёр Талын төлөөлөгчид байлцах

Хэлэлцэн тохирогч нэг Талын төлөөлөгчид Хэлэлцэн тохирогч нөгөө Талын төв байгууллагын зөвшөөрлөөр түүний нутаг дэвсгэрт нь эрх зүйн туслалцаа үзүүлэх тухай даалгавар биелүүлэх үед байлцаж болно

62 дугаар зүйл
Таслан шийдвэрлэх тогтоолын тухай мэдэгдэх
болон бусад мэдээлэл

1. Хэлэлцэн тохирогч Талууд Хэлэлцэн тохирогч нөгөө Талын иргэний хувьд Хэлэлцэн тохирогч нэг Талын шүүхээс гаргасан хуулийн хүчин төгөлдөр болсон таслан шийдвэрлэх тогтоолын талаар харилцан мэдэгдэж байна.
2. Хэлэлцэн тохирогч хоёр Тал шаардлага өгсөн Хэлэлцэн тохирогч Талын иргэн бус хүний хувьд түүний ял шийтгэгдсэн буюу хэрэв уг этгээд шаардлага өгсөн Хэлэлцэн тохирогч Талын нутаг дэвсгэрт эрүүгийн хариуцлагад татагдаж буй бол Хэлэлцэн тохирогч нэг Талын шүүхийн гаргасан хуулийн хүчин төгөлдөр болсон таслан шийдвэрлэх тогтоолын талаарх мэдээллийг харилцан үндэслэл бүхий хүсэлтээр өгч байна.
3. Хэлэлцэн тохирогч хоёр Тал боломжийн хэрээр энэ зүйлийн 1, 2 дахь хэсэгт дурдсан этгээдийн хурууны хээг харилцан хүссэний дагуу шилжүүлж байна.

63 дугаар зүйл
Ял шийтгэлийн тухай мэдээ

Хэлэлцэн тохирогч хоёр Тал нь байцаан шийтгэх ажиллагааны зорилгод үндэслэсэн хүсэлтийн дагуу Хэлэлцэн тохирогч нөгөө Талын иргэнд хамаарах ял шийтгэгдсэн тухай мэдээ болон тухайн мэдээ хэрэв шаардлага хүлээн авсан Хэлэлцэн тохирогч Талын хууль тогтоомжийн дагуу бүртгэлд ордог бол сүүлд гарсан таслан шийдвэрлэх тогтоолын тухай шийдвэрийн талаарх мэдээг бие биедээ дамжуулж байна.

64 дүгээр зүйл
Шилжүүлэн өгсөн мэдээллийг хэрэглэх

Энэхүү Гэрээний 62, 63 дугаар зүйлийн дагуу өгсөн мэдээллийг зөвхөн өгсөн зорилгод нь ашиглах бөгөөд уг мэдээллийг өгсөн Хэлэлцэн тохирогч Талын зөвшөөрөлгүйгээр гуравдагч улсад дамжуулж болохгүй.

ДӨРӨВДҮГЭЭР БҮЛЭГ
ХОРИХ ЯЛ ШИЙТГЭГДСЭН ЭТГЭЭДИЙГ ЯЛ
ЭДЛҮҮЛЭХЭЭР ШИЛЖҮҮЛЭХ

65 дугаар зүйл
Нийтлэг заалт

1. Хэлэлцэн тохирогч хоёр Тал энэ бүлэгт заасны дагуу Хэлэлцэн тохирогч нэг Тал /цаашид "Таслан шийдвэрлэх тогтоол гаргасан улс" гэх/-ын шүүхээр хорих ял шийтгэгдсэн этгээдийг болон Хэлэлцэн тохирогч нөгөө Талын иргэнийг харьяат улсад /цаашид "Таслан шийдвэрлэх тогтоол гүйцэтгэх улс" гэх/ нь ял эдлүүлэхээр харилцан шилжүүлэх үүрэг хүлээнэ.
2. Энэхүү бүлгийг Таслан шийдвэрлэх тогтоол гүйцэтгэх улсын нутаг дэвсгэрт байнга оршин суугаа этгээдэд нэгэн адил хэрэглэнэ.
3. Ялтан этгээдийг ял эдлүүлэхээр шилжүүлэх тухай саналыг Таслан шийдвэрлэх тогтоол гаргасан улс болон Таслан шийдвэрлэх тогтоол гүйцэтгэх улсын аль аль нь гаргаж болно.
4. Шаардлага хүлээн авсан Хэлэлцэн тохирогч Тал шаардлага өгсөн Хэлэлцэн тохирогч Талд ялтан этгээдийг шилжүүлэн авахыг зөвшөөрсөн буюу шилжүүлэн өгөхөөс татгалзаж буй тухайгаа нэн даруй мэдэгдэнэ.

66 дугаар зүйл
Ялтан этгээдийн эрх

1. Ялтан этгээд, түүнчлэн түүнийг төлөөлөх буюу ойрын садан төрлийн хүмүүс /гэр бүлийн хүн, эцэг, эх, үр хүүхэд, үрчлэн авагчид, үрчлүүлэгсэд, төрсөн ах, эгч, өвөө, эмээ, ач нар/ шилжүүлэн авах тухай

- өргөдөл явуулах боломжийг хянан шийдвэрлэх хүсэлтийн хамт Хэлэлцэн тохирогч аль ч Талын эрх бүхий байгууллагад хандах эрхтэй.
2. Таслан шийдвэрлэх тогтоол гаргасан улсын эрх бүхий байгууллага ялтан этгээдэд энэ зүйлийн 1 дэх хэсэгт заасан түүний эрх болон эрх зүйн үр дагаврын талаар мэдээлэх ёстой.

67 дугаар зүйл **Шилжүүлэх тухай хүсэлт**

1. Шилжүүлэх тухай хүсэлтийг бичгээр үйлдэнэ.
2. Таслан шийдвэрлэх тогтоол гаргасан улсын хүсэлтэд дараахь зүйлийг хавсаргана:
 - 1/гүйцэтгэвэл зохих таслан шийдвэрлэх тогтоолын болон дээд шатны шүүхийн шийдвэр гарсан бол түүний баталгаат хуулбар, мөн түүнчлэн таслан шийдвэрлэх тогтоол хуулийн хүчин төгөлдөр болсон тухай баримт бичиг;
 - 2/гэмт этгээдийг хорих ял шийтгэхэд үндэслэл болсон хуулийн заалт;
 - 3/ялын эдэлсэн хэсэг буюу ялын эдэлбэл зохих тэр хэсгийн тухай мэдээллийг агуулсан баримт бичиг;
 - 4/хэрэв нэмэлт ял оноосон бол түүнийг гүйцэтгэх тухай баримт бичиг;
 - 5/ялтан этгээдийн болон 68 дугаар зүйлийн 2 дахь хэсэгт заасны дагуу түүнийг төлөөлөх хүний гарын үсэг бүхий шилжүүлэхийг зөвшөөрсөн тухай баримт бичиг;
 - 6/иргэний харьяалал болон байнгын оршин суугаа газрыг баталсан баримт бичиг байгаа бол уг баримт бичиг;
 - 7/шилжүүлэх тухай асуудлыг шийдвэрлэхэд ач холбогдолтой байж болох бусад баримт бичиг.
3. Таслан шийдвэрлэх тогтоол гүйцэтгэх улсын хүсэлтэд дараахь зүйлийг хавсаргана:
 - 1/ялтан этгээдийн иргэний харьяалал болон байнгын оршин суугаа газрыг нотолсон баримт бичиг;
 - 2/гэмт этгээдийн хорих ял шийтгэгдсэн үйлдэл нь таслан шийдвэрлэх тогтоол гүйцэтгэх улсад гэмт хэрэг гэж үзэх хуулийн заалт.Шилжүүлэхийг зөвшөөрсөн тохиолдолд Таслан шийдвэрлэх тогтоол гаргасан улс энэ зүйлийн 2 дахь хэсгийн 1-5 дахь заалтад дурдсан баримт бичгийг өөрийн зөвшөөрлийн тухай мэдээлэлд хавсаргана.
4. Хэлэлцэн тохирогч Тал бүр шилжүүлэх тухай хүсэлт тавихын өмнө буюу шилжүүлэх тухай шийдвэр гаргахын өмнө энэ зүйлийн 2, 3 дахь хэсэгт дурдсан баримт бичгийг шаардаж болно.
5. Таслан шийдвэрлэх тогтоол гаргасан буюу Таслан шийдвэрлэх тогтоол гүйцэтгэх улсын гаргасан хүсэлт болон шийдвэрийн тухай ялтан этгээдэд бичгээр мэдэгдэнэ.

68 дугаар зүйл **Шилжүүлэх нөхцөл**

Энэ бүлэгт заасны дагуу ялтан этгээдийг дараахь тохиолдолд шилжүүлнэ:

- 1/таслан шийдвэрлэх тогтоол хүчин төгөлдөр болж, хорих ялын эдлээгүй хугацаа нь зургаан сараас доошгүй бол;
- 2/ялтан этгээдээс түүнийг шилжүүлэхийг зөвшөөрсөн, хэрэв тэрээр тийм зөвшөөрлөө илэрхийлж чадахгүй бол түүний хууль ёсны төлөөлөгч нь зөвшөөрсөн бол;
- 3/тухайн этгээдийн шийтгэгдсэн үйлдэл нь Таслан шийдвэрлэх тогтоол гүйцэтгэх улсын хууль тогтоомжийн дагуу гэмт хэрэг байх бөгөөд эсхүл уг үйлдлийг Таслан шийдвэрлэх тогтоол гүйцэтгэх улсын нутаг дэвсгэрт үйлдсэн тохиолдолд ч гэмт хэрэг мөн бол;
- 4/Хэлэлцэн тохирогч нэг Талын хууль тогтоомжийн дагуу таслан шийдвэрлэх тогтоол гүйцэтгэхэд хөөн хэлэлцэх хугацаа дууссан бол;
- 5/таслан шийдвэрлэх тогтоолыг эчнээ гаргаагүй бол;
- 6/Таслан шийдвэрлэх тогтоол гүйцэтгэх улсад тухайн этгээд уг үйлдэлдээ шийтгэгдээгүй буюу цагаатгагдаагүй, эсхүл хэргийг хэрэгсэхгүй болгоогүй бол;
- 7/шаардлага хүлээн авсан Хэлэлцэн тохирогч Талын саналаар энэ нь тусгаар тогтнол, аюулгүй байдал, нийгмийн хэв журам болон бусад чухал ашиг сонирхолд хохирол учруулахгүй бөгөөд хэрэв Хэлэлцэн тохирогч энэ Талын хууль тогтоомжийн үндсэн зарчим болон олон улсын үүрэгт харшлахгүй бол;
- 8/Хэлэлцэн тохирогч Талууд шилжүүлэх тухай зөвшилцөнд хүрсэн бол.

69 дүгээр зүйл **Шилжүүлэх**

Шилжүүлэхийг зөвшөөрсөн тохиолдолд Хэлэлцэн тохирогч хоёр Талын эрх бүхий байгууллагууд ялтан этгээдийг шилжүүлэх цаг хугацаа, газар болон журмыг тодорхойлох бөгөөд шаардлагатай үед дамжин өнгөрүүлэх тухай асуудлыг сонирхогч улстай зөвшилцөнө.

70 дугаар зүйл
Таслан шийдвэрлэх тогтоолыг гүйцэтгэх

1. Хэрэв таслан шийдвэрлэх тогтоолыг гүйцэтгэхээр хүлээн авбал Таслан шийдвэрлэх тогтоолыг гүйцэтгэх улсын шүүх гүйцэтгэвэл зохих хорих ялын хугацааг Таслан шийдвэрлэх тогтоол гаргасан улсын шүүхийн шийдвэрт тогтоосон хугацаагаар тодорхойлно.
2. Таслан шийдвэрлэх тогтоол гүйцэтгэх улсын тогтоосон хорих ялын хугацаанд ялтан этгээдийн таслан шийдвэрлэх тогтоол гаргасан улсад эдэлсэн ялын хугацааг оруулан тооцно.
3. Хэрэв Таслан шийдвэрлэх тогтоол гүйцэтгэх улсын хууль тогтоомжид зааснаар уг гэмт хэрэгт оногдуулах хорих ялын хэмжээ нь таслан шийдвэрлэх тогтоолд зааснаас бага байвал, Таслан шийдвэрлэх тогтоол гүйцэтгэх улс нь уг гэмт хэргийг үйлдэхэд оногдуулах өөрийн хууль тогтоомжид заасан хорих ялын дээд хэмжээгээр тодорхойлно.
4. Таслан шийдвэрлэх тогтоол гүйцэтгэх улсын хууль тогтоомжийн дагуу үйлдсэн уг гэмт хэрэгт хорих ял шийтгэхээр заагаагүй бол таслан шийдвэрлэх тогтоол гүйцэтгэх улсын шүүх өөрийн улсын хууль тогтоомжийн дагуу таслан шийдвэрлэх тогтоолоор оногдуулсан зохих шийтгэлийг тодорхойлно.
5. Таслан шийдвэрлэх тогтоол гүйцэтгэх улс түүнийг гүйцэтгэхээр хүлээн авсны үр дүнд ялтан этгээдийн ял эдлэх нөхцөл байдал нь Таслан шийдвэрлэх тогтоол гаргасан улсад ял эдлэх нөхцөл байдлаас ямар ч тохиолдолд байж болохгүй.
6. Таслан шийдвэрлэх тогтоолоор оногдуулсан нэмэгдэл ялыг гүйцэтгээгүй нөхцөлд Таслан шийдвэрлэх тогтоол гүйцэтгэх улсын шүүх уг нэмэлт шийтгэлийг энэ улсын хууль тогтоомжид уг гэмт хэргийг үйлдэхэд тийм ял оногдуулахаар заасан бол тодорхойлно. Нэмэгдэл ялыг энэ зүйлд заасан журмаар тодорхойлох ба гүйцэтгэнэ.

71 дүгээр зүйл
Хүсэлт шийдвэрлэсэн тухай мэдэгдэх

Таслан шийдвэрлэх тогтоол гүйцэтгэх улс таслан шийдвэрлэх тогтоолыг гүйцэтгэхээр хүлээн авах тухай хүсэлтийг ямар хэмжээгээр барагдуулсан тухайгаа Таслан шийдвэрлэх тогтоол гаргасан улсад аль болох богино хугацаанд мэдээнэ. Хүсэлтийг бүрэн хэмжээгээр буюу зарим хэсгийг нь барагдуулахаас татгалзвал энэ тухай үндэслэлээ гаргана.

72 дугаар зүйл
Шийтгэлийг гүйцэтгэх нөхцөл, журам

Шийтгэлийг гүйцэтгэх нөхцөл, журмыг Таслан шийдвэрлэх тогтоол гүйцэтгэх улсын хууль тогтоомжоор тодорхойлно.

73 дугаар зүйл
Ялтан этгээдийн баталгаа

Таслан шийдвэрлэх тогтоол гүйцэтгэх улсад ял эдлүүлэхээр шилжүүлсэн ялтан этгээдийг үйлдсэн хэрэгт нь холбогдох таслан шийдвэрлэх тогтоол хойшлогдсон, шинээр мөрдөн байцаалт явуулах болон шүүх хэргийг хянан хэлэлцэхээр зааснаас бусад тохиолдолд уг үйлдлийн учир энэ улсад эрүүгийн хариуцлагад дахин татаж болохгүй.

74 дүгээр зүйл
Уучлал ба өршөөл үзүүлэх

Ялтан этгээдийг таслан шийдвэрлэх тогтоол гүйцэтгэх улс уучлал үзүүлж болно. Таслан шийдвэрлэх тогтоол гаргасан улс нь Таслан шийдвэрлэх тогтоол гүйцэтгэх улсад уучлал үзүүлэх тухай хүсэлтээ гаргаж болно.

75 дугаар зүйл
Таслан шийдвэрлэх тогтоолыг дахин хянах

1. Таслан шийдвэрлэх тогтоол гүйцэтгэх улсад ял эдлүүлэхээр шилжүүлсэн ялтан этгээдийн хувьд таслан шийдвэрлэх тогтоолыг зөвхөн уг тогтоол гаргасан улсын шүүх дахин хянана. Таслан шийдвэрлэх тогтоол гаргасан улс таслан шийдвэрлэх тогтоолын талаар гаргасан өөрчлөлтийг Таслан шийдвэрлэх тогтоол гүйцэтгэх улсад нэн даруй мэдээнэ.
2. Таслан шийдвэрлэх тогтоол гүйцэтгэх улс Таслан шийдвэрлэх тогтоолыг гаргасан улсаас ял шийтгэл гүйцэтгэх шаардлагагүй гэсэн мэдэгдэл авмагц түүнийг гүйцэтгэхээ нэн даруй зогсооно.

3. Хэрэв ялтан этгээдийг ял эдлүүлэхээр шилжүүлсний дараа Таслан шийдвэрлэх тогтоол гаргасан улсад уг тогтоол өөрчлөгдсөн болон шинээр байцаан шийтгэх ажиллагаа явуулахаар буюу шүүхээр хянан хэлэлэхээр болсон бол энэ тухай шийдвэрийн хуулбарыг болон шинээр хэргийг хянан шийдвэрлэхэд шаардлагатай бусад материалыг Таслан шийдвэрлэх тогтоол гүйцэтгэх улсад энэ улсын хууль тогтоомжийн дагуу түүнийг хариуцлагад татах асуудлыг шийдвэрлүүлэхээр хүргүүлнэ.

76 дугаар зүйл

Таслан шийдвэрлэх тогтоол гүйцэтгэхийг мэдэгдэх

Таслан шийдвэрлэх тогтоол гүйцэтгэх улс Таслан шийдвэрлэх тогтоол гаргасан улсад:

- 1/ялтан этгээд ялаа эдэлсэн;
- 2/хэрэв ялтан этгээд оргосон буюу бусад байдлаар ял эдлэхээс зайлсхийж байгаа;
- 3/Таслан шийдвэрлэх тогтоол гаргасан улс уг тогтоолын гүйцэтгэлийн явцын тухай хүсэлт гаргасан тохиолдолд тус тус мэдэгдэнэ.

77 дугаар зүйл

Таслан шийдвэрлэх тогтоол гүйцэтгэсний эрх зүйн үр дагавар

Таслан шийдвэрлэх тогтоол гүйцэтгэх улсад ял эдлүүлэхээр шилжүүлсэн ялтан этгээдийн хувьд тухайн улсад тийм хэрэг үйлдсэн ялтан этгээдийг шийтгэсний үр дагавартай адил эрх зүйн үр дагавар үүснэ.

78 дугаар зүйл

Таслан шийдвэрлэх тогтоол гүйцэтгэхтэй холбогдсон зардал

Ялтан этгээдийг шилжүүлэх болон ял шийтгэл гүйцэтгэхтэй холбогдсон зардлыг нутаг дэвсгэр дээр нь уг зардал гарсан Хэлэлцэн тохирогч Тал хариуцна.

79 дүгээр зүйл

Үйлчлэх цаг хугацааны хязгаар

Энэ бүлгийн заалтууд энэ Гэрээ хүчин төгөлдөр болохоос өмнө шийтгэгдсэн ялтан этгээдэд нэгэн адил хэрэглэгдэнэ.

Дөрөвдүгээр хэсэг ТӨГСГӨЛИЙН ЗААЛТ

80 дугаар зүйл

1. Энэхүү Гэрээ нь Хэлэлцэн тохирогч хоёр Талын байгуулсан бусад олон улсын гэрээнээс үүдэн гарах тэдний эрх, үүргийг хөндөхгүй.
2. Энэхүү Гэрээний заалтыг тайлбарлах болон хэрэглэхтэй холбогдож санал зөрвөл түүнийг харилцан зөвлөлдөх замаар шийдвэрлэнэ.
3. Энэхүү Гэрээг соёрхон батлах бөгөөд Батламж жуух бичгийг солилцсон өдрөөс эхлэн хүчин төгөлдөр болно. Батламж жуух бичгийг Москва хотноо солилцоно.
4. Энэхүү Гэрээг таван жилийн хугацаатай байгуулав. Хэрэв Хэлэлцэн тохирогч аль нэг Тал Гэрээний хугацаа дуусахаас зургаан сарын өмнө Гэрээг цуцлах тухайгаа Хэлэлцэн тохирогч нөгөө Талд бичгээр мэдэгдээгүй бол энэхүү Гэрээ дараагийн таван жил тутам аяндаа сунгагдана.
5. Энэхүү Гэрээ хүчин төгөлдөр болсон өдрөөс эхлэн 1988 оны 9 дүгээр сарын 23-нд Улаанбаатар хотноо гарын үсэг зурсан Бүгд Найрамдах Монгол Ард Улс, Зөвлөлт Социалист Бүгд Найрамдах Холбоот Улсын хооронд "Иргэн гэр бүлийн болон эрүүгийн хэргийн талаар эрх зүйн туслалцаа харилцан үзүүлэх тухай Гэрээ" Хэлэлцэн тохирогч Талуудын хувьд дуусгавар болно.
6. Энэ зүйлийн 5 дахь хэсэгт дурдсаны дагуу Гэрээ дуусгавар болоход энэхүү Гэрээний үндсэн дээр Хэлэлцэн тохирогч нөгөө Талын нутаг дэвсгэрт хүлээн зөвшөөрсөн болон гүйцэтгэж буй Хэлэлцэн тохирогч нэг Талын байгууллагын шийдвэр хүчин төгөлдөр хэвээр үлдэнэ.

Энэхүү Гэрээг 1999 оны дөрөвдүгээр сарын 20-ны өдөр Улаанбаатар хотноо монгол, орос хэлээр тус бүр хоёр хувь үйлдсэн бөгөөд эх бичвэрүүд адил хүчинтэй байна.